Чанга цааз, чанартай цэрэг, чигч жонон, чадмаг жанжин чанадсыг дийлэх үндэс

Чингис хаан

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.05.09, ЛХАГВА ~ №094 (893) ~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~ ҮНЭ: 1000₮

Ерөнхийлөгчид хамаарах бүрэн эрхийг булааж, урьдчилан эдэлж болохгүй

УИХ-ын гишүүдээс хэд дахин их мэдээлэл сэтгүүлчдэд байгааг харлаа. >2

FT FINANCIAL TIMES

Бизнес, эдийн засгийн төрөлжсөн суваг Financial Times-ийн нийтлэлүүдийг албан ёсны эрхтэйгээр хүргэж байна.

Компанийн үнэлгээнд талууд санал нэгдэхэд хугацаа их шаарддаг

"IPO Conference 2018" хямд санхүүжилт татах сайн туршлагыг хуваалцана. >11

ZGM DAILY

Aduunchuluun's license conflict to be resolved

Area coincided with MAK LLC has a coal reserve of 40-50 million tons. > 7

ОНЦЛОХ


УЛС ТӨР

АТГ-ын удирдлагуудын томилгоог хэлэлцвэл хууль зөрчинө гэж ХЗБХ үзлээ.
Ерөнхий сайдын томилолт Баянхонгор аймагт үргэлжилж байна.
Нийслэлийн МАН-ын Бага хурал зургадугаар сарын 7-нд болж, даргаа томилно.
Сонгуулиас хойш Увсад 300 гаруй төрийн албан хаагч ажлаасаа чөлөөлөгджээ.

ЭДИЙН ЗАСАГ

Төсвийн орлого энэ онд ДНБ-ий 27 хувьд хүрэх төлөвтэй байна.
Хөрөнгийн биржийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулна.
Нүүрсний ханш улирлын чанартайгаар тогтворжих хандлагатай боллоо.
Татварын багц хуулийн шинэчлэлд 3638 санал ирсэн гэж Сангийн яам мэдэгдлээ.
ТОП 20 индекс 19,595.45 нэгж болж, 0.18 хувиар унав.

ТОР-20 индекс
(хувиар)



НИЙГЭМ

Гэр хорооллын нохойд эрүүл мэндийн үзлэг хийж, галзуугийн эсрэг вакцин тарина.
Монгол эрчүүдийн 7.5 хувь нь үргүйдэлтэй нь тогтоогджээ.
Эмч, сувилагчид тайван жагсаал хийж, цалин нэмүүлэх шаардлага тавилаа.
Монгол-Солонгосын най-рамдлын цэцэрлэгт хүрээлэнгийн шавыг Дамбадаржаад тавив.

ДЭЛХИЙ

Кубын шинэ Ерөнхийлөгч эх орондоо гадаадын хөрөнгө оруулалт татахыг хүсэж байна.
Энэтхэгийн онлайн худал-дааны Flipkart-ийг нэгтгэх тэмцэлд Walmart ялагч болов.
Ази, Номхон далайн бүсийн үнэт цаас газрын тосны үнэтэй зэрэгцэн өслөө.
Японы БОЯ хугацаа нь дуусах дөхсөн хүнс ахиу хэрэглэхийг иргэдэд уриалав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2018.05.09

14° 0°

ҮҮЛ БАГАСНА

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

АКАДЕМИК ЭРХ ЧӨЛӨӨ БА ҮНЭ ЦЭНТЭЙ АЖИЛТАН БЭЛТГЭХ ЭХЛЭЛ



Дээд боловсролын шинэчлэл төслийн үр дүнд орон нутгийн оюутнуудын төсөл удирдах, албан бичиг хөтлөх чадварууд эрс сайжирчээ. Ингэснээр ажил олгогчдын шаардлагад нийцсэн мэргэжилтнүүд хөдөлмөрийн зах зээл дээр гарч байна. ▶4

Б.Хасуй / ЗГМ©

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Цаг үеэсээ хоцорсон цаасан лавлагааг халах нь

Б.Энхжаргал
@enkhjrgIZGM


Иргэн нэг газраас нөгөө рүү шилжихийн тулд хорооноосоо хасалт хийлгэнэ. Хасалт хийлгэснийг нь тодорхойлох нарийн хуудсаа бариад нөгөө хороон дээр очдог. Тэмдэгтийн хураамжийг хүртэл нэр зааж өгсөн банкинд тушааж, буцаж баримтыг харуулна. Манай улсын мөнгөний нийлүүлэлтийн 90 гаруй хувь нь бэлэн бус хэлбэрт шилжчихээд байхад төрийн үйлчилгээ л цаасан дэвсгэртээ нэхээстэй. Санхүүгийн байгууллагын санах ой ийм өндөр түвшинд хүрчихээд байхад төрийнх нь мөн л цаасан хэлбэрт, цоожтой сейфэнд хадгалаастай буй.

Төр өөртөө байгаа мэдээллийг иргэдээс нэхэж нааш цааш явуулж, энд тэнд дугаарлуулж, цаас зараад байдгийн учир нь юу вэ.

Оюуны өмч, улсын бүртгэлийн газрын дарга асан Р.Содхүү манай байгууллагад тодорхой хэмжээний хүнд суртал байх ёстой гэж хэлээд ажлаасаа халагдсан. Ухаандаа тус байгууллагаас гаргаж өгдөг зарим лавлагааг хэн авч буйг тагнуул, цагдаагийнхан шалгадаг, түүнд хугацаа хэрэгтэй гэсэн санааг эвийг нь олж илэрхийлэх чадваргүй өвгөн дарга өөрөө өөрийнхөө тойрохыг зуруулсан нь тэр юм.

▶3

ЗГМ: ИНФОГРАФИК



ЭДИЙН ЗАСАГ

Гаднынхан тоодоггүй салбарт дотоодын компаниуд тоглолт хийдэг

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Уул уурхайн үндсэн нэрийн түүхий эдэд алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр, жонш, газрын ховор элемент зэрэг байгалийн эрдэс баялаг дээгүүр эрэмбэлэгддэг. Эдгээр нь экспортын дийлэнх хэсгийг бүрдүүлж, төсөвт жил бүр их наяд төгрөгөөр хэмжигдэх орлого төвлөрүүлж ирсэн. Тэгвэл гадаад зах зээлд тодийлэн эрэлттэй бус ч дотоодод өргөн ашиглаж буй түүхий эд бол элс, хайрга, дайрга. Барилга, зам, гүүрийн бүтээн байгуулалт эрчимжихэд нийслэл болон орон нутагт эдгээр түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт эрс нэмэгддэг. Ялангуяа, ДНБ-ий 75 хувийг бүрдүүлж буй Улаанбаатарыг тойрсон элс, хайрганы үйлдвэрлэл идэвхжиж байна. Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг давхардсан тоогоор 230 гаруй аж ахуйн нэгж эзэмшиж буй.

Өнгөрсөн хугацаанд түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хэт замбараагүй олгосон нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй энэ төрлийн бизнест олон компани хуйлрахад хүргэжээ.

▶12

FT FINANCIAL TIMES

Путин эдийн засгийн том зорилт дэвшүүллээ

Кэтрин Хилл

Владимир Путин эрүүлийг хамгаалах, боловсролын салбарт асар их зардал гаргах замаар амьдралын нөхцлийг эрс сайжруулж, ОХУ-ын зогсонги эдийн засагт шинэ эрч хүч өгөх амлалттайгаар Ерөнхийлөгчийн шинэ засаглалаа эхлүүллээ.

Дахин зургаан жил Ерөнхийлөгчөөр ажиллах тангараг өргөснөөсөө хойш хэдхэн цагийн дараа ноён Путин шинэ зарлигт гарын үсэг зурлаа. Засгийн газар шинжлэх ухаан, технологи, нийгэм, эдийн засгийн үсрэнгүй хөгжилд чиглэн ажиллах ёстойг уг зарлигт заажээ.

Ерөнхийлөгчийн төлөвлөгөө тодорхой бус, популист шинжтэй, зарим нь үл гүйцэлдэх санаа агуулж байгааг шинжээч өгүүлсэн юм. Засгийн газар улс орныг хөгжүүлэх найман зорилтот төлөвлөгөөг Ерөнхийлөгчийн хугацаа дуусах 2024 он гэхэд хэрэгжүүлэх ёстойг ноён Путин онцолжээ.

ОХУ-ыг дэлхийд эдийн засгаар тэргүүлэгч гол таван улсын нэг болгох, ядуурлыг одоогийн түвшнээс 50 хувиар багасгах зэрэг зорилт уг төлөвлөгөөнд багтаж байна.

▶9

АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1309.50 0.35%	6826 0.01%	96.290 0.06%	110.81 0.01%	97.34 0.23%	2,402.94	377.37	38.13

Улс төр

УЛС ТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Ерөнхийлөгчид хамаарах бүрэн эрхийг булааж, урьдчилан эдэлж болохгүй

УИХ-ын гишүүдээс хэд дахин их мэдээлэл сэтгүүлчдэд байгааг харлаа

Б.Баярмаа
@bayarmaaZGM



С.Батсайхан / ЗГМ©

УИХ-ын гишүүн Л.Болдтой цаг үеийн асуудлаар ярилцлаа.

-Ерөнхийлөгч АТГ-ын дарга, дэд даргыг шинээр томилуулах саналаа УИХ-д хүргүүлсэн. Харин МАН-ын бүлэг, Хууль зүйн байнгын хорооны хурлаар эдгээр албан тушаалтнуудын бүрэн эрхийн хугацаа дуусаагүй учраас уг саналыг хүлээж авах боломжгүй гэж үзлээ. Үүнд АН-ын бүлгийн гишүүд ямар байр суурьтай байна вэ?

-АТГ-ын дарга, дэд даргын албан тушаалд томилуулах саналаа өргөн барих бүрэн эрх Ерөнхийлөгчид байдаг. Ерөнхийлөгчөөр сонгогдсон бол сонгуулийн дараа эрхийнхээ дагуу нэр дэвшигчийн нэрийг оруулж ирэх ёстой биз дээ. Гэтэл сонгуульд хэн ч гарч ирж магадгүй гэвч сонгуулиас өмнө өөрийн хүнээ томилдог, байр суурийг нь баталгаажуулдаг. Дараа нь хэн ч гарсан өмнөх тогтолцоонд томилогдсон хүнийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болно. Ийм муухай жишиг практикт тогтох гэж байна. Өөрөөр хэлбэл одоогийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг томилогдохоос нь өмнө булааж аваад, урьдчилсан эдэлж байна. Хэрэв бид одоо л энэ муухай жишгийг засахгүй бол хэзээ ч дуусахгүй чөтгөрийн тойрог эхэлнэ. Ажлаа өгч байгаа хүн нь дараагийн хүнээ томилоод явна гэдэг ёс суртахуунгүй явдал.

-Танай бүлэг энэ асуудлыг хэзээ хэлэлцэх вэ?

-Хуулийн дагуу санал оруулсан учраас энэ бол ярих ёстой сэдэв. Ямар ч байсан цаг гаргаж байгаад хэлэлцэх ёстой. АТГ-ын даргаар хэн томилогдох нь чухал биш. Харин ард түмний сонголтоор, сонгуулиар гарч ирсэн дараагийн хүн нь бүрэн эрхээ эдэлж чадахгүй ийм тогтолцоо руу явах нь. "Эрдэнэт үйлдвэр"-ийг барьцаалж зээл авсан, хуурамчаар гарын үсэг зурсан зэрэг муу арга төрд яваад байна. Ард түмний сонголтыг хүлээн зөвшөөрөхгүй байхаар энэ ардчилсан тогтолцоо чинь ажиллах уу, үгүй юу гэдэг талаас нь би харж байна.

-Өнөөдөр Хууль зүйн байнгын хороо С.Зориг агсны хэргийн талаар хаалттай хуралдсан. Ямар шийдвэр, чиглэл гарсан бэ?

-Байнгын хорооны дэргэд хоёр долоо хоногийн өмнө Ажлын хэсэг байгуулагдсан. Уг Ажлын хэсэгтээ тодорхой чиглэл өгч чадаагүй. Мөн УИХ-ын 40 гишүүн энэ асуудлаар УИХ-ын дэргэд түр хороо байгуулъя гэсэн шийдвэр гаргасан. Ингээд цаг хугацаа их алдаж байгаа. Энэ хоорондоо ажлын хэсэгт орсон хоёр гишүүнийг УЕПГ-аас С.Зоригийн хэрэгт холбоотойгоор шалгаж байгаа гэсэн мэдээлэл хийлээ. Үүнээс болж гишүүдийн зүгээс маш олон асуулт тавьж байгаа. Энэ талаар хаалттай хуралдаж, тайлбар өгсөн.

Хурлаар нэгдүгээрт өмгөөлөгч нарыг ил тод сонсъё гэсэн шийдвэр гарлаа. Хоёрдугаарт прокурорын байгууллага хэвлэлийнхэнд мэдээлэл өгч байгаа юм бол дараагийн удаа Хууль зүйн байнгын хорооны гишүүд мэдээлэл авъя гэж шийдсэн. Хуулийнхан олон түмний нүдэнд ил ярьчихаад хуурна гэвэл хэцүү.

-Ц.Нямдорж сайд С.Зоригийн хавтаст хэрэгтэй танилцах ямар ч боломжгүй. Хэрэв танилцсан бол хууль зөрчсөн үйлдэл болно гэж тайлбарлаж байгаа. Ер нь гишүүд С.Зоригийн хэргийн талаар ямар мэдээллэлтэй, мэдээллийг хэрхэн авч байна вэ?

-Үүнийг Ц.Нямдорж сайд өөрөө тайлбарлах байх. Хууль зүйн байнгын хороонд яригдаж байгаа бүх асуудлыг харахад энэ хэрэгтэй танилцсан, мэдээлэл авсан нэг ч УИХ-ын гишүүн алга. Бүгд л хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авч байгаа.

Ажлаа өгч байгаа нь дараагийн хүнээ томилоод явах нь ёс суртахуунгүй явдал

Харин УИХ-ын гишүүдээс хэд дахин их мэдээлэл сэтгүүлчдэд байгааг телевизээр харлаа. Бидний сонсож байгаагүй маш их шинэ мэдээлэл байсан.

-АТГ-аас УИХ-ын гишүүн Ж.Батзандан та хоёрыг дуудсан. Энэ хэрэг юу болж байна вэ?

-Б.Хурцыг томилоход гомдол гаргасан иргэдтэй УИХ-ын зургаан гишүүн уулзсан. Тэр гомдлын тухайд хэрэг үүсгэж байна гэж бодсон, үгүй юм билээ. Харин иргэдийг сонссон нь эрх мэдлээ хэтрүүлсэн хэрэг гэж шалгаж байгаа юм байна. УИХ-ын гишүүдэд хууль санаачлах гэх зэрэг хэд хэдэн эрх бий. Харин энэ дунд иргэдээ сонсох эрх гэж алга. Тиймээс хуульд заагаагүй эрх эдэлсэн гээд хэрэгт татаж байгаа нь цаанаа улс төрийн зорилготой гэж харж байна. Тухайлбал, Үндсэн хуульд амьд явах эрхтэй гэж бий. Харин агаар амьсгалах эрхтэй гэж байхгүй. Гэтэл агаар амьсгалах эрх нь хуульд бичигдээгүй учраас амьсгалж болохгүй гэсэн үг биш шүү дээ. Агаар амьсгалахгүй яах юм бэ. Үүн шиг УИХ-ын гишүүн иргэдээ сонсохгүй юм бол яаж иргэдээ төлөөлөх вэ.

-Б.Хурцын гэрийн хаягтай холбоотой асуудал нэг тийш болж чадсан уу?

-Зайсан дахь хаягт нь очихоор байхгүй гээд намайг зургаан сар гүйлгэлээ. Тэгсэн атлаа яг тэр хаягаараа Ж.Батзандан гишүүнийг хоёр шатны шүүхээр ялчихсан байдаг. Нөгөө АСЕМ хотхон дахь хаягаар нь бичиг өгөхөд Баянзүрх дүүргийн шүүхээс буцаасан. Дахиад Зайсан дахь хаягаар нь өгөөд өчигдөр анх удаа тайлбар авлаа. Тэр талаас дуртай хаягаа өгөхөөр нь шүүх, прокурор нь зөвшөөрөөд байдаг. Харин энэ талд нь Зайсан дахь гэрийнх нь хаягаас болж Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийн өргөдөл гацсан байгаа. Надаас гадна хоёр, гурван хүний гомдол хаягаас болж гацсан. Эндээс харахад нэг хүн бусдаасаа илүү нөлөө, эрх мэдэлтэй байна гэсэн үг.

-Танай хамын гишүүн С.Баярцогт, Ч.Сайханбилэг нарыг үргэлжлүүлэн хорьж байна. АН-ын бүлгийн зүгээс ямар алхам хийхээр төлөвлөж байна вэ?

-Энэ бол зөвхөн намын биш улсын асуудал. Монгол Улсын нэр хүнд, хууль тогтоомж хэрэгжих эсэх асуудал. Ерөнхий сайд асан Ч.Сайханбилэг маш тодорхой үндэслэлийг захидалдаа дурдсан байсан. Хуулийн байгууллагууд тэр бүх үндэслэлийг нягталж үзэх байх. Үүний цаана улс төрийн захиалга байх ёсгүй. Ерөнхий сайд, жирийн иргэн, хэн ч байсан улс төрийн захиалгаар хуулийн байгууллагын буруу хайчинд орж болохгүй. Хэрэв тийм бол бид эцсээ хүртэл явна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ЗАСГИЙН ГАЗАР
Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн албан томилолт Баянхонгор аймагт үргэлжилж байна. Энэ үеэр Засгийн газраас тус аймагт иж бүрэн трактор, гар трактор, хонь, ямаа хяргах төхөөрөмж, малын вакцин болон хүн эмнэлгийн хоёр автомашин гардуулав.

» НАМУУД
Нийслэлийн МАН-ын 34-р бага хурал ирэх сарын эхээр хуралдах тов гарлаа. Уг хуралд, намын анхан шатны байгууллага, үүрүүдээс нийт 369 төлөөлөгч оролцох бөгөөд Нийслэлийн МАН-ын шинэ дарга тодрох юм.

» УИХ
НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцэж, дэмжлээ. Уг гэрээг соёрхон баталснаар манай орны газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд нэн шаардлагатай ган халуун, өвчин хортонд тэсвэртэй, ургац өндөртэй, чанартай хүнс, тэжээлийн шинэ таримал, түүний сортуудыг бий болгох, сайжруулахад дэлхийн таримал ургамлын генетик нөөцийг чөлөөтэй ашиглах боломж бүрдэх юм.

» УУЛЗАЛТ
Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийн ахлагчаар С.Бямбацогт гишүүн ажилладаг. Тэрбээр Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн /International IDEA/-гийн төлөөлөлтэй уулзлаа. Талууд улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт, түүнийг тайлагнах журам, намын гишүүний татвар, хандив, төрөөс улс төрийн намд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн харьцаа болон дээрх хуулийн төслийг боловсруулахад хамтран ажиллах талаар санал солилцлоо.

ЭШЛЭЛ



-"Оюутолгой"-н гэрээнд нэг том алдаа бий. Тухайн үеийн поп улстөрчид, цээжээ дэлдсэн эх орончдын гайгаар хувь эзэмшинэ гэж "Оюутолгой"-н олборлох үйлдвэрлэлд 34 хувийг авснаас болж бид өрөнд орсон. Түүнээс биш энэ төслийг эхлүүлсэн нь алдаа байгаагүй. Уг нь хөрөнгө оруулагчид ямар зардлаар, ямар хугацаанд, яаж ухаж авах нь тэдний л асуудал. Үүнд Монголын төр оролцох ямар ч шаардлага байгаагүй. Харин ямар татвар авах, байгалийн баялгийнхаа хувь хишгийг яаж хүртэх, хил гааль болон байгаль орчны хяналтаа яаж хийхээ шийдээд баялагтай холбоотой мөнгөөрөө эдийн засгаа солонгоруулах ёстой байсан юм. Эх орончдын "эд баялгаа бид ингэж л мэддэг" гэсэн солиорлоос болоод баялгийн хувь эзэмших биш баялгийг ухаж гаргаж ирэх компанид хувь эзэмшдэг болчихсон.

УИХ-ын гишүүн асан
Х.Тэмүүжин

ТОМИЛОЛТ

Төрийн албанд нам дагасан халаа их байна гэв



Э.Соёл
ЗГМ

Ерөнхийлөгч Х.Баттулга баруун гурван аймгийн иргэдтэй уулзаж, санал бодлыг нь сонслоо. Тэрбээр энэ сарын 5-7-ны өдрүүдэд Ховд, Баян-Өлгий, Увс аймагт ажилласан юм.

Ховд аймаг жилд дунджаар 15.6 мянган тонн мах, 1.7 мянган тонн ноос, 514.1 тонн ноолуур, 300 мянган ширхэг арьс, шир үйлдвэрлэдэг. Махны хэрэгцээгээ 100 хувь, төмсний хэрэгцээгээ 100 хувь, сүүний хэрэгцээгээ 85.6 хувь, хүнсний ногооны хэрэгцээгээ 100 хувь дотоодын үйлдвэрлэлээс хангаж байгаа юм байна. Гэвч нутгийн иргэд ажлын байр хомс, цалин болон тэтгэврийн хэмжээ бага байгаа талаар хөндөж байлаа. Мөн хүүхдийн мөнгийг ялгавартай олгож байгаад цөөнгүй иргэд бухимдаж байсан юм. Харин Баян-Өлгий аймагт хийсэн уулзалтаар бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого хэрэгжихгүй байгаа талаар гомдол, санал олон гарсан юм. Ядаж импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлд төрөөс дэмлжэг үзүүлэх шаардлагатай байгааг орон нутгийн бизнес эрхлэгчид онцоллоо.

Увс аймгийн иргэд уулзалтын үеэр төрийн албанд нам дагасан томилгоо, халаа сэлгээ их байгааг анхаарууллаа. 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш тус аймагт нийт 300 гаруй хүнийг ажлаас нь чөлөөлсөн байна. Хуулийн байгууллага ажилд нь буцааж томилох шийдвэр гаргасан ч хэрэгжихгүй байгаад анхаарахыг иргэд Ерөнхийлөгчөөс хүссэн юм. [ЗГМ]

БАЙНГЫН ХОРОО

АТГ-ын удирдлагуудын томилгоог хэлэлцсэнгүй

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хурлаар АТГ-ын албан тушаалтнуудыг шинээр томилох саналыг хэлэлцэх товтой байсан ч хэлэлцсэнгүй. АТГ-ын дарга Х.Энхжаргал, дэд дарга Ц.Нямдорж нарын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Д.Даваа-Очирыг даргаар, Ж.Батсайханыг дэд даргаар тус тус томилуулах саналыг Ерөнхийлөгчөөс ирүүлсэн юм.

АТГ-ын одоогийн дарга, дэд дарга нар албан тушаалаасаа чөлөөлөгдөх өргөдөл өгөөгүй, бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болох болоогүй тул хэлэлцэх шаардлагагүй гэж тус Байнгын хорооны гишүүдийн 80 хувь нь үзжээ. УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар "Хууль зүйн байнгын хороо энэ асуудлыг хэлэлцэх юм бол хууль зөрчих нөхцөл үүсэх нь. Өөрөөр хэлбэл, энэ асуудлыг хэлэлцээд дэмжсэн, дэмжээгүй ямар нэг шийдвэр гаргавал Байнгын хороо, УИХ Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг зөрчсөн асуудал үүснэ" гэж тайлбарлалаа. [ЗГМ]

ЦАХИМ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ

Огноо: 2018.05.09-н

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:
АВТОМАШИНЫ БЕНЗИН КАРТ НӨХЦӨЛӨӨР НИЙЛҮҮЛЭХ компанийг сонгон шалгаруулах тендер
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: МИАТ/201801004Б

МИАТ ХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **"АВТОМАШИНЫ БЕНЗИН КАРТ НӨХЦӨЛӨӨР НИЙЛҮҮЛЭХ"** тухай хялбаршуулсан цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн дундаж борлуулалтын орлого 1,5 тэрбум төгрөгөөс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 800 сая төгрөгөөс багагүй байна.

Санхүүгийн чадавхийг харуулах: 2015, 2016, 2017 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, аудитийн дүгнэлтийн хамт.

Сүүлийн **3** жилийн аль нэг хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг **800 сая** төгрөгөөс багагүй байх, мөн жагсаалтыг ирүүлэх.

Нефтийн бүтээгдэхүүн борлуулах тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт **21,200,000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 06-р сарын 11-ны өдрийн 11.00 цагаас** нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 06-р сарын 11–ны өдрийн 11 цаг 30 минутанд** нээнэ.

Жич дээрх шалгаруулалтыг цахимаар шалгаруулна. **/www.tender.gov.mn/**

Гадаадын хуулийн этгээд тендерт оролцох боломжгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ХАЯГ:
Хан-Уул дүүрэг, 10-р хороо
МИАТ ХК
Харилцах утас: 7004-9860, 91914093
Факс: 976-11-7004-9919
Өрөөний дугаар : Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

› **INFO@ZASAG.CO**

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

92 сая хуудас цаасан мэдээллийг цахимжуулах ажил арван жил үргэлжилж буй ч дуусаагүй



Чипэнд хүний овог нэр, хаяг, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал төлсөн мэдээлэл, цусны бүлэг, харшилтай эмийн мэдээлэл зэрэг өгөгдлүүдийг суулгахаар ажиллаж байна.

С.Батсайхан / ЗГМ©

Цаг үеэсээ хоцорсон цаасан лавлагааг халах нь

◀1

Тэгвэл бүртгэлийн байгууллага хүний хувийн мэдээллээс хурууны хээ, улсынхаас нууцын зэрэглэлтэй үл хөдлөх хөрөнгөөс бусад бүх өгөгдлийг ил болгохоор бэлтгэж байна.

Төрийн нийт үйлчилгээний 65-70 хувийг бүртгэлийн байгууллага үзүүлдэг. Хууль зүй, дотоод хэргийн яамны өгсөн мэдээллээр хувь хүний, аж ахуйн нэгжийн, эд хөрөнгийн гээд нийт 122 төрлийн мэдээллийг бүртгэлийн байгууллага өгдөг. Гэтэл эдгээрийн ердөө 10 үйлчилгээг л иргэд онлайнаар авах боломжтой. 2017 онд гэхэд онлайнаар өгдөг 10 лавлагааг давхардсан тоогоор дөрвөн сая хүн авчээ. Түүнээс гадна ТҮЦ машинаар 1.5 сая лавлагаа авсан талаарх статистик байна. Гадаад паспортын үйлчилгээг 350 мянган иргэн, аж ахуйн нэгжийн шинэ нэр авах гэсэн 60-80 мянган хүн гээд боддоо. Энэ хэрээр Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагууд иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ажиллах ёстой.

Дээнч чадахгүй байгаагийн шалтгаан нь бүртгэлийн байгууллагын хуулиудтай холбоотой аж. Монгол Улсад интернэт, байгууллага хоорондын дундын мэдээллийн сүлжээ төдийлэн сайжраагүй, аймгууд шилэн кабельд холбогдоогүй үед дээрх хуулиудыг баталсан. Тиймээс л бүх лавлагаа, мэдээлэл цаасан хэлбэрээр бугшиж, иргэдийг зуун айл руу чихэлдэхээс өөр аргагүй байдалд оруулдаг. Өнөөдрийн байдлаар нийт 92 сая хуудас цаасан лавлагаа Оюуны өмч, улсын бүртгэлийн газарт байгаа. Энэ мэдээллийг цахим хэлбэрт оруулах ажлыг 10 жилийн турш хийж байгаа ч, одоо 70 хувийнх нь л ард гарсан гэж Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр хэлж байсан.

Мөн янз бүрийн шалтгаанаар бусад хуулийг дагалдуулж бүртгэлийн багц хуулиудыг өөрчилсөөр, нөхөөсөөр дүүрсэн авцалдаагүй хууль болсныг нэмж тайлбарласан. Гэтэл бүртгэлийн байгууллага зарим үйлчилгээгээ цахим болгох боломж байдаг ч хуулийг нь өөрчилж өгдөггүй өдийг үзэж буй. Цаг үеийн шаардлагаар бий болсон зарим харилцааг сайдын, газрын даргын журмаар зохицуулах нь ч бий. Хуулиас давсан ийм журмууд бүртгэлийн ажилтны хүнд суртлыг өөгшүүлж, иргэдийг нааш цааш явуулсан, энд тэнд дугаарлуулсан, уур уцаарыг нь барсан ажил болоод буй нь өнөөдрийн 100 айлын бүртгэлийн газрын дүр төрх. Тэгвэл бүртгэлийн ерөнхий хуулийн гол шинэчлэл нь юу вэ. УИХ-д өргөн бариад жил гаруй дарагдаж буй уг төслийг хэлэлцэх боломжит хугацааг парламент хүлээсээр өдийг хүргэв. Бүртгэлийн ерөнхий хуулиар бүртгэлийн мэдээллийн сан маш нууцын зэрэглэлтэй байна гэж заасныг юун түрүүнд өөрчлөх учиртай. Тус сан доторх мэдээллийн яг аль нь нууц байх, юуг нь хязгаартай гаргах, алийг нь нээлттэй байлгахыг тодорхой зааж өгөх ёстой. Маш нууцын зэрэглэлд байх өгөгдлийг дээр өгүүлсэн. Тэр нь төрийн үл хөдлөх хөрөнгө, иргэний хурууны хээ.

● Төрийн нийт үйлчилгээний 65-70 хувийг бүртгэлийн байгууллага үзүүлдэг.

● 2017 онд гэхэд онлайнаар өгдөг 10 лавлагааг давхардсан тоогоор дөрвөн сая хүн авчээ.

● Мэдээллийг цахим хэлбэрт оруулах ажлыг арван жилийн турш хийж байгаа ч, одоо 70 хувийнх нь л ард гарсан.

Харин хязгаартайгаар буюу төлбөртэй өгөх мэдээлэлд үл хөдлөх хөрөнгийн барьцааны лавлагаа, хуулийн этгээдийн нэр болон хаягийн байршил, газрын гэрчилгээ гэх мэт орно.

Иргэн, аж ахуйн нэгж банкнаас зээл авахын тулд үл хөдлөх хөрөнгөө барьцаалдаг. Гэхдээ тухайн хөрөнгө өөр хаа нэгэн газар барьцаалагдаагүйг батлахын тулд шаардлагатай лавлагааг бүртгэлийн байгууллагаас авах шаардлага үүсдэг. Хамгийн эрэлттэй лавлагаанд ордог энэ үйлчилгээг хязгаартайгаар буюу тодорхой хэмжээний төлбөр төлж, цахимаар авах боломжийг хуулийн төсөлд оруулжээ.

Мөн төрийн байгууллага хоорондын бүртгэл мэдээллийн зөрүүг арилгахад хуулийн төслийн зорилго чиглэж байгаа. Жишээ хэлэхэд, төрөх эмнэлэгт амаржсан 240 мянган ээжийн регистрийн дугаарыг ЭМД-ын сангаас шүүж үзэхэд 13 мянга нь УБЕГ-т байдаг мэдээлэлтэй зөрж байжээ. Энэ бол төрийн байгууллага хоорондын мэдээлэл зөрүүтэй байдгийн энгийн жишээ. Ялангуяа, сонгуулийн үеэр хаягийн асар их зөрүү бүртгэлийн байгууллагад гардаг. Гэтэл оршин суух хаягийг хорооны дарга дугаараар олгочихдог, түүнийгээ бүртгэлийн сандаа оруулдаггүй. Үүнээс болж сонгууль болохоор таньж мэдэхгүй баахан хүнтэй нэг өрх болсноо иргэд мэддэгийн учир нь энэ юм.

Дараагийн асуудал иргэний үнэмлэхний чипэнд ямар мэдээлэл байх вэ. Анх нэвтрүүлэхдээ цахим үнэмлэх гэж нэрлэсэн ч, тэр ид шидийг нь монголчууд үзэлгүй арван жил болсон. Харин ч эсрэгээрээ иргэний үнэмлэхээ өөрөө барьчихаад, мөн болохыг нь натриатаар батлуулах гэзэг явдаг. Тэгвэл тус чипэнд хүний овог нэр, хаяг, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал төлсөн мэдээлэл, цусны бүлэг, харшилтай эмийн мэдээлэл зэрэг өгөгдлүүдийг суулгахаар ажиллаж байна.

Монгол Улс 1997 оноос орон сууцыг хувьчилж эхэлсэн. Харин газар хувьчлалыг 2003 оноос эхлүүлсэн. Зургаан жилийн хугацаатай хэрэгжиж эхэлсэн энэ хоёр хууль газар болон үл хөдлөх хөрөнгийг тус тусад бүртгэсэн. Ингэж үл хөдлөх хөрөнгийг бүртгэж эхэлснээс хойш 20 жил, газрыг гэрчилгээжүүлснээс 15 жилийн дараа 200 мянга гаруй байшин, 400 гаруй мянган газрын эзэмших, ашиглах эрх хууль ёсоор баталгаажаагүй байдлыг бий болгожээ.

Төрийн үл хөдлөх хөрөнгө, иргэний хурууны хээг нууцад хамруулна

Мэдээллийн сангууд тусдаа байгаатай холбоотойгоор ийм асуудал үүссэн гэж Засгийн газар үзэж байгаа. Тиймээс үүнийг шийдэх нь Бүртгэлийн ерөнхий хуулийн бас нэгэн зорилго. Ингэхдээ дундын мэдээллийн санг Үндэсний дата төв дээр бий болгох юм. Улмаар үл хөдлөх хөрөнгө, газрын мэдээллийг нэг дугаар дээр бүртгэнэ. Гэхдээ энэ ажлыг албан журмаар бус явцын дундаа шийдэхээс аргагүй. Ажлын хэсгийн харж буйгаар 10-20 жилийн дараа энэ байдал цэгцэрнэ. [ЗГМ]



“ТАНЫ КАРТ, ТАНЫ ТАСАЛБАР” АЯНЫ ЭХНИЙ ХОЁР АЗТАН ХӨЛБӨМБӨГИЙН ДАШТ ҮЗЭХ БАТЛАМЖАА ГАРДАН АВЛАА

2018 оны 05-р сарын 09, Лхагва гариг

ХААН Банкнаас хөлбөмбөгийн ДАШТ-ийг тохиолдуулан орон даяар зарласан “Таны карт, таны тасалбар” картын урамшуулалт аяны эхний хоёр азтан 05-р сарын 05-ны Бямба гаригт МҮОНТ-ийн 1-р сувгийн шууд нэвтрүүлгээр тодорсон билээ.

“Таны карт, таны тасалбар” картын урамшуулалт аяны хөлбөмбөгийн ДАШТ-ий хагас шигшээ тоглолтыг дэргэдээс нь үзэх азтай харилцагчдаар Улаанбаатар хотын харилцагч Ю.Энхбат, Г.Магнай нар тодорч, батламжаа гардан авлаа. Ийнхүү дэлхий нийтээр чих тавин, амьсгаа даран хүлээдэг хөлбөмбөгийн ДАШТ-ийг дэргэдээс нь үзэж, хөлбөмбөгийн гайхалтай тоглолтуудыг цаг алдалгүй үзэх эрхтэй болсон харилцагчиддаа баяр хүргэе.

Аяны хүрээнд ХААН Банкны бүх төрлийн виза картаа ашиглан ХААН Банкны карт уншигч ПОС машин дээр 300,000 төгрөг болон түүнээс дээш дүнгээр гүйлгээ хийсэн эсвэл гадаад улсад картаараа 300,000 төгрөг болон түүнээс дээш дүнгээр гүйлгээ хийсэн бүх харилцагч тохиролд оролцох эрхтэй болох юм.

Тус аян 05-р сарын 31-ний өдрийг дуустал орон даяар үргэлжлэх бөгөөд нийт дөрвөн азтай харилцагчийг тодруулна. Дараагийн хоёр дахь азтанг 06-р сарын 01-ний Баасан гаригт МҮОНТ-ийн шууд нэвтрүүлгээр тодруулна. Эрхэм харилцагчид та бүхэн аяны хугацаанд ХААН Банкны бүх төрлийн виза картаа ашиглан 300,000 болон түүнээс дээш дүнгээр гүйлгээ хийж, хөлбөмбөгийн ДАШТ-ийг дэргэдээс нь үзэх дараагийн азтанаар тодрох боломж нээлттэй буйг дуулгаж байна.

Та аяны тухай дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.khanbank.com хаягт хандан эсвэл 1800-1917 дугаарт залгах боломжтой.

1800-1917 дугаарт холбогдон мэдээлэл авна уу. **www.khanbank.com** вэбсайтад зочлоорой. **131917 дугаарт "FIFA" гэж бичин** тохирлын эрхээ шалгаарай.

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



ЗГМ: Сурвалжилга

Ажил олгогчдын шаардлагад нийцсэн мэргэжилтнүүдийг орон нутагт бэлтгэж байна

З.Цэлмэг
@tselmegZGM



Азийн хөгжлийн банкны дэвд боловсролын чанарыг дэлхийн жишигт хүргэхээр хийсэн ажлынх нь багахан хэсэг нь газрын тосны бүтээгдэхүүн шинжлэх лаборатори юм.

С.Батсайхан / ЗГМ©

Академик эрх чөлөө ба үнэ цэнтэй ажилтан бэлтгэх эхлэл

Монголын зүүн бүсийн боловсролын салбарын тулах цэг болсон Дорнод их сургууль цагийн эрхээр боловсон хүчний бодлогоо өөрчилж эхэлжээ. Нийгмийн ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг байсан тус сургууль хэдэн жилийн өмнөөс байгалийн ухаанд онцгой анхаарах болов. Үүнийг тод томруун харуулах нэг жишээ нь тус сургууль саяхан газрын тосны бүтээгдэхүүн шинжилдэг иж бүрэн лабораторитой болсон явдал. Азийн хөгжлийн банкнаас 2012-2019 онд хэрэгжүүлж буй дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд тус сургуульд 293.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсний нэг нь 107 сая төгрөг бүхий уг лаборатори юм. “Саяхан манай сургуульд салбарын яам болон АМГТГ-ын мэргэжилтнүүд ирж лабораторийг маань үзээд хүчин чадал сайтайд нь олзуурхаж, хурдан ашиглалтад оруулж үр дүнг нь үзэхийг захисан” хэмээн Дорнод их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Э.Ундармаа Азийн хөгжлийн банкны төлөөлөлтэй уулзахдаа ярилаа. Ирэх жил тус сургуулийг газрын тосны инженерийн мэргэжлээр төгсөж буй анхны мэргэжилтнүүд хөдөлмөрийн зах зээлд гарна.

Монгол орны газрын тосны өлгий нутагт хүчин чадал сайтай, сүүлийн үеийн тоног төхөөрөмжтэй лабораторийг түшиглэн боловсон хүчин бэлтгэж эхэлсэн нь үргэлж шүүмжлэлийн бай болдог боловсролын салбарын хувьд нэн таатай мэдээ юм. “Инновац, шинэ технологид дасан зохицох чадвар, хөгжил нэвтрүүлэх чадавх бол тухайн улсын эдийн засгийн өсөлтөд маш чухал үүрэг гүйцэтгэдэг” хэмээн Азийн хөгжлийн банкны суурин төлөөлөгч, хатагтай Ёланда Фернандез Ломмен манай сонинд өгсөн ярилцлагадаа онцлов. Тиймээс ч дээд боловсролын салбарт мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх чөлөөг хангалттай байлгах, төгссөн мэргэжилтнүүд нь ажил олгогчдын шаардлагад нийцдэг байх нь хөдөлмөрийн зах зээлээр хоорондоо холбогддог макро эдийн засаг ба дээд боловсролын салбарын гол зорилго. Ийм жишигт дээд боловсролын чанарыг хүргэхээр хийсэн ажил, санхүүжилтынх нь багахан хэсэг нь газрын тосны бүтээгдэхүүн шинжлэх лаборатори юм. “Манай улс Газрын тос боловсруулах үйлдвэртэй болохоор зорьж, Засгийн газар энэ салбарт гадаад ажилчдын тоог цөөлж, дотоодын ажиллах хүчнийг нэмэгдүүлэх бодлого баримталж буй энэ үед уг хөрөнгө оруулалт аймгийн тулгамдсан асуудлыг шийдлээ” хэмээн Засаг дарга М.Бадамсүрэн хатагтай Ёландад талархал илэрхийлсэн. Сургуульдаа лабораторитой болох төслөө тус сургуулийнхан 2015 оны арваннэгдүгээр сард бичиж, дараа сард нь санхүүжилт авах эрхтэй болсон аж. Харамсалтай нь, төсөл боловсруулах багт газрын тосны чиглэлийн нарийн мэргэжилтэн байхгүйгээс тоног төхөөрөмжийн жагсаалтаа дутуу өгчихжээ. Үүний улмаас одоо сорох шүүгээ, аналитик жин, нэрлэгийн аппарат, октан тодорхойлогч гэсэн дөрвөн тоног төхөөрөмж алга. Хайран сайхан тоног төхөөрөмжүүдээ оюутнууд нь гүйцэд ашиглаж чадахгүй, танхимын хойморт үзүүлэнгийн үүрэг гүйцэтгэж байгаа нь харамсалтай.

Тус лабораторид тулгамдаж буй өөр нэг асуудал бол менежментийг нь хариуцах лаборант, профессор олдохгүй байгаа юм байна. “Улс орон даяар зар тавиад ч ирдэггүй. Цалин хангамж, бүс нутгийн хөгжлийг голдог байх” хэмээн Э.Ундармаа учирлав. Уг нь газрын тосны олборлогч болон шатахуун импортлогчид хамтран ажиллах сонирхлоо илэрхийлээд буй аж. Дорнодын их сургуулийн Инновац, гадаад харилцааны албаны мэргэжилтэн С.Энхжаргал “Лабораторийн менежменттэй холбоотой асуудал их чухал. Байнгын ажиллагаатай байх, засвар үйлчилгээ тогтмол хийдэг байх хэрэгтэй. Бид анхнаасаа төслөө бичихдээ нээлттэй лаборатори байгуулж, бүсийн компаниудад төлбөртэй үйлчилгээ үзүүлэх замаар зардлаа нөхөх, санхүүжилт босгохыг зорьсон” гэж ярилаа.

Азийн хөгжлийн банкны боловсролын салбар хариуцсан ахлах мэргэжилтэн Л.Итгэл “Лабораторийн зарим тоног төхөөрөмж дутуу, ажиллуулах мэргэжилтэн байхгүй байгааг харах үнэхээр харамсалтай байна. Сургууль хариуцлагагүй хандаж, бэлтгэл дутуу хийсний илрэл. Гэхдээ нэгэнт манайхаас хөрөнгө оруулсан тул бид дутууг нь авч өгнө” хэмээв.

Лаборатори байнгын үйл ажиллагаатай болсноор Монголд газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудтай хамтран ашиглах, газрын тосны инженерийн чиглэлээр хавсарга болон суурь судалгааг бүс нутгуудын болон улсын хэмжээнд хийж, хэрэгжүүлэх өргөн боломж нээгдэж буй юм.

АЖИЛ ОЛГОГЧДЫН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАЖ ЭХЭЛЛЭЭ

Ажил горилогчдын хувьд бичгийн харилцааны болон багаар ажиллах чадвар, задлан шинжлэх, санаачилгатай шийдэмгий байх чадварууд дипломын голч дүнгээс нь илүү чухал болохыг ХНХЯ-наас ажил олгогчдын дунд явуулсан судалгаанд бий. Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд ажил олгогчдын дээрх хэрэгцээг хангах нэгэн сонирхолтой төсөл хэрэгжүүлсэн нь “Оюутнуудын санаачилгыг дэмжих төв” юм. Оюутнууд санаачилгаа ажил хэрэг болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлснээр ажил хийх сонирхол нь нэмэгдсэн байна. Тухайлбал, “Маамуу” үсчний салоны төсөл орлого олох боломжтой учир оюутнууд маркетинг хийх, харилцагч татах гэх мэт бие даан бизнес эрхлэх чадваруудаа хөгжүүлэхэд ихээхэн дэмжлэг болжээ. Одоо тус салонд үсчний чиглэлээр ажиллах сонирхолтой оюутнууд цагаар ажилладаг.

Энэ төсөл хэрэгжсэнээр оюутнууд төслөө төлөвлөгөөний дагуу хийх, удирдлагаар хангах, эрсдэлээ тооцох, тайлан боловсруулах гээд төслийн удирдлагын чадвар нь эрс сайжирсан гэдгийг С.Энхжаргал онцоллоо. Өөрөөр хэлбэл, төсөлд хөрөнгө оруулалт татах, дэмжлэг авахад саад болдог төслийн зорилт, үр дүнг ерөнхийлөх гэх мэт монголчуудын гаргадаг түгээмэл алдаа багасаж байна гэсэн үг. Үүний зэрэгцээ албан бичиг боловсруулах, багаар ажиллах чадвар, сэтгэл зүйгээ удирдаж, зорилгынхоо төлөө тууштай явдаг чадварууд нь хөгжсөн аж. “Төсөл хэрэгжсэний дараа эрсдэлээ тооцоолж хэрхэн даван туулах вэ гэсэн асуудал шийдэх чадвар маш сайн хөгжсөн гэж оюутнууд хариулсан байна. Одоо уг жишгийг тус сургууль үргэлжлүүлж буй бөгөөд оюутнууд холбоогоороо дамжуулж цагийн ажил хийдэг болжээ.

ЯПОН ХҮҮХДҮҮД МОНГОЛЫН ТУХАЙ СУРАЛЦАЖ БАЙНА

Дорнод их сургуульд байгуулсан зайн сургалтын төвд сайн дурын ажилтан Мина Япон сурагчдад Монголын тухай хичээл зааж, мэдээлэл түгээж байна. Биднийг зайн сургалтын танхимаар ороход Архангай аймаг дахь МУБИС-ийн зайн сургалтын төвөөс холбогдсон байлаа. Иймэ төвүүдийг Баян-Өлгий, Завхан дахь их сургуулиудад Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд мөн байгуулсан бөгөөд 19 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилладаг аж. Зайн сургалтын төвтэй болсноор орон нутагт ахисан түвшний сургалт явуулах, төгсөгчдийн мөшгөх судалгаа хийх, гадаадын мэргэжилтэн, профессоруудын сургалтад хамрагдах, эрдэм шинжилгээний илтгэл, судалгааныуудаар цахим сан үүсгэж, төлбөртэй үйлчилгээ үзүүлэх боломж бүрджээ.

Засгийн газраас боловсролын салбарт баримталж буй бодлогын хүрээнд 2022 он гэхэд орон нутгийн ЕБС-ийн багш нарын 70 хувийг магистрын зэрэгтэй болгоход Дорнод их сургуулийн зайн сургалтын төв чухал хувь нэмэр оруулж буйг захирлын үүрэг гүйцэтгэгч Э.Ундармаа онцолсон. Тус сургуулийн төгсөгчид зүүн бүс дэх цэцэрлэг болон ЕБС-ийн багш нарын 80 орчим хувийг хангадаг аж. Уг төв одоогоор аймгийн дөрвөн сумтай холбогдог бөгөөд энэ он гарсаар таван удаагийн онлайн хичээл, хоёр хэлэлцүүлэг өрнүүлсэн байна.

Оюутнуудын төсөл удирдах, албан бичиг боловсруулах чадвар сайжирчээ

Орон нутаг дахь боловсролын аяллын хүрээнд санхүүжүүлэгч байгууллагын урмыг хугалж, нутаг нэгтнүүдийнхээ өмнөөс нүүр улайх бас нэг явдал болжээ. Төслийн хүрээнд Дорнод их сургуулийн биеийн тамирын заалыг иж бүрэн шинэчлэхээр 86 сая төгрөгийн дэмжлэг үзүүлжээ. Харамсалтай нь, гүйцэтгэгч байгууллага болон сургуулийн удирдлагын хариуцлагагүйн улмаас өдгөө тэр их мөнгөний нэлээд нь салхинд хийсэв. Гүйцэтгэгч компани зориулалтын бус шал тавьснаас хүмүүс халтирч унаж, гэмтэх болсон тул хуучин шалаа буцаан тавьсан, хана нь чанар муутай гээд санхүүжүүлэгчээ гонсойлгож хариуцлагагүй хандсан байв. Хатагтай Ёланда “Биеийн тамирын заал чанар болон дизайны хувьд та бүхний сэтгэлд хүрээгүй, хүмүүс унаж, гэмтсэнд харамсалтай байна. Гүйцэтгэгч байгууллагыг шалгая.” хэмээв. Харин Азийн хөгжлийн банкны боловсрол хариуцсан мэргэжилтэн Л.Итгэл “86 сая төгрөг их мөнгө. Үүний зарцуулалт ийм хангалтгүй байгаад сэтгэл дундуур байна. 2014 онд энэ заалыг зассан. Манай журмаар гүйцэтгэгч тал нэг жилийн баталгаа өгдөг. Тухайн үед яагаад мэдэгдэж болоогүй юм бэ. Тэгсэн бол дахиж хийлгэж болох байсан. Үүнд сургуулийн удирдлага ч бас хариуцлагагүй хандсан байна” гэсэн юм. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99909472
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

ubinfo.mn

Дугаарын удирдагч
Л.Сугармаа

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018.05.09-ний өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:
ГАШУУН СУХАЙТ АВТО ЗАМЫН ШНЦ 1, 3-ЫН ӨРГӨТГӨЛИЙН АЖИЛ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:
ЭМГЛ/201802017

“Эрдэнэс Монгол” ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Гашуун сухайт авто замын ШНЦ-1, 3-ын өргөтгөлийн ажлыг гүйцэтгэх тухай** битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) үнэ төлбөргүйгээр татан авах боломжтой бөгөөд тендерт оролцохын тулд эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50’000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон ажлын туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017он/-ын борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас доошгүй байна.
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас доошгүй байна.
Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017он
Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2015, 2016, 2017 оны аль нэг жилд нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас доошгүй үнийн дүнтэй ижил төстэй ажилд үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.
Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: ЗТХЯ-наас олгодог 2.8.1, 2.8.6, 2.8.8, 2.8.9

Тендерт оролцогч нь тендерийн хамт захиалагчийн төсөвт өртгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөг (эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валют)-ийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем **(www.tender.gov.mn)**-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр **2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 10 минут-д** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх “эрхгүй”.
Дотоодын давуу эрх “тооцохгүй”.

“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК
УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, 1 ДҮГЭЭР ХОРОО,
ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ-15, МОННИС ЦАМХАГ, 14 ДАВХАРТ
УТАС:75553399-249

Цаг үе

Х.Баттулга: Би Монголоо ард түмэн нь аз жаргалтай, нийгэм нь хөгжингүй, эдийн засаг нь бие даасан байгаасай гэж хүсдэг



Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга 1963 оны гуравдугаар сарын 3-нд Улаанбаатар хотноо төржээ. Ерөнхий боловсролын сургуулиа төгсмөгцөө тэрбээр Дүрслэх урлагийн сургуульд элсэв. 1982 онд Х.Баттулга Зураачдын холбоонд ажиллаж байв. Харин 1979-1990 онд Монгол Улсын самбо бөхийн үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтаж байлаа. Х.Баттулга 1983 онд Украины Киев хотод зохион байгуулагдсан Самбо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож, алтан медаль хүртэж байсан түүхтэй. Харин 1986 болон 1990 онд мөнгөн медаль хүртсэн юм.

2004 онд тэрбээр УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Улмаар 2008-2012 онд Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, 2012-2014 онд Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байв. Харин 2017 оны долдугаар сарын 7-нд УИХ-д цөөнх болсон Ардчилсан намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж, ялалт байгуулсан юм. Монгол Улсын Төрийн тэргүүнээр сонгогдсоныхоо дараа тэрбээр ОХУ-ын "Forbes Russia" сэтгүүлд ярилцлага өгснийг танд толилуулж байна.

Екатерина Губина

СПОРТ

-Сайн байна уу. Юуны өмнө, Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчөөр сонгогдсонд баяр хүргэе. Та бол самбо бөхийн дэлхийн аварга. Иймээс ярилцлагаа спортын салбараас эхэлье. Та спортын хамгийн дуртай төрлөө нэрлэхгүй юу?

-Мэдээж, бөх. Тэр дундаа жүдо.

-Тулааны урлагийн ямар философи танд ойр байдаг вэ?

-Бөх хүн өөрийн гэсэн философитой. Надад Монголын үндэсний бөхийн барилдаан болон жүдогийн үзэл санаа ойр байдаг. Энэ спортод нийтлэг зүйл их бий, гэхдээ ялгаатай зүйл ч бий. Үндэсний бөхийн барилдаан нь жүдотой адил уламжлал, ахмад настан, дасгалжуулагч нараа хүндэтгэхэд тус дэмтэй. Мөн бөхчүүд спортын салбар болон амьдрал дээр биеэ зөв авч явж сурдаг. Монголын үндэсний бөхийн барилдааны мэхэд гар хөлийн хөдөлгөөнийг хязгаарладаггүй. Харин жүдо бөхөд гар гарынхаа эсрэг, хөл хөлийнхөө эсрэг мэх хийх шаардлагатай байдаг. Жүдогийн хатуу дэглэм хүнийг сахилга баттай болгодог.

-Таны хамгийн хүчтэй өрсөлдөгч спорт, улс төр эсвэл бизнесийн салбарын алинд нь байв?

-Мэдээж улс төрд, миний өрсөлдөгчид.

-Та өрсөлдөгчийнхөө үйлдлийг урьдчилан таамаглах чадвартай юу?

-Бөх хүн бүр өрсөлдөгчийнхөө үйлдлийг урьдчилан таамаглах чадвартай байх ёстой. Улмаар түүндээ тохирсон хариу үйлдэл үзүүлдэг. Энэ нь тамирчин хүнийг ялалтад хүргэх гол арга. Спортын дадал, зуршил үргэлж ашигтай байдаг. Тэр дундаа улс төрд маш их хэрэгтэй. Гэхдээ улс төр бол мэдээж хэцүү. Бөхийн барилдаанд би нэг хүний үйлдлийг урьдчилан таамаглаж чадна. Харин улс төрд маш олон тоглогч бий шүү дээ.

-Тамирчин хүний зөн билэг Монгол Улсын хөгжлийн ирээдүйг төсөөлөхөд тусалдаг уу?

-Магадгүй ээ. Гэхдээ амьдралаа спорттой нягт холбох, эсвэл улс төрийн карьераа спортын нэр томьёогоор тайлбарлах шаардлагагүй. Миний улс төрд орсон гол шалтгаан бол би эх орныхоо ирээдүйг бүтээлцэхэд өөрийн хувь нэмрээ оруулах л гэсэн юм.

УЛС ТӨР ЭДИЙН ЗАСАГ

-Өнөөдрийн Монгол Улсыг та хэрхэн харж байна вэ. Сул болон давуу талыг нь тодорхойлбол?

-Монгол Улсад маш олон сул тал бий гэдгийг би ойлгож байна. Гэхдээ бид тэрхүү сул талыг нь давуу тал болгох боломжтой. Монголын эдийн засаг хямралтай байна гэж хүн бүр ярьж байна. Монгол Улсын эдийн засаг уул уурхайн гаралтай түүхий эдийн экспортоос хараат. Гэхдээ энэ бол түр зуурын үзэгдэл. Хүмүүс улстөрчдийг алдаатай бодлого хэрэгжүүлж байгааг ойлгож эхэлж байна. Гэхдээ бидэнд алдаагаа залруулах боломж бий. Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлынхаа үеэр би улс эх орноо хөгжүүлэх мөрийн хөтөлбөрөө танилцуулсан. Иймээс өөрийн багтайгаа хамтран тэрхүү мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэллээ. Бид Монгол Улсын сул талыг давуу тал болгохын төлөө ажиллах болно.

-Монгол Улсад ямар бизнесийг та тэргүүлэх чиглэл гэж харж байна вэ?

-Орос, Монголын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэр бол хоёр улсын хамтын ажиллагааны тод илрэл байсан. "Эрдэнэт" үйлдвэрийн туршлага бидэнд бүтээгдэхүүнээ боловсруулах боломжтой гэдгийг харуулсан.

● Гажуудсан ардчиллаас үүдэлтэйгээр монголчууд олон жилийн үр дүнгүй улс төрийн намаас залхаж байна.

● Харамсалтай нь, Монгол Улс төрийн бодлогодоо үндэсний ашиг сонирхлыг харгалзан үздэггүй.

● Ажлын байр бий болгож буй, монголчуудад үр өгөөжтэй, экспортод чиглэсэн хөрөнгө оруулалтыг би үргэлж дэмждэг.

-Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын нөөц бололцоог хэрхэн үзэж байна вэ?

-Бид хөдөө аж ахуйн салбартаа чухал ач холбогдол өгч байна. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 80 орчим хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байна. Энэ салбарт хүн амын 42 хувь нь ажилладаг. Энэ тоон үзүүлэлт бол гурван сая хүн амтай Монгол Улсын хувьд томоохон үзүүлэлт. Жил бүр бид 10 сая арьс шир ялган авч байна. Гэхдээ энэ нь хангалттай биш. Хэрвээ бид арьс шир боловсруулах үйлдвэртэй болбол бүтээгдэхүүнээ экспортлох бүрэн боломжтой болно.

-Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж байхдаа та "Монгол ялна" гэсэн уриаг дэвшүүлсэн. Энэ нь ямар утга агуулж байна вэ?

-Миний мөрийн хөтөлбөрийн товч агуулга монголчуудыг эх орондоо сэтгэл ханамжтай, сайхан амьдруулах, ядуурлыг бууруулахад оршино. Мэдээж, хүндрэл, бэрхшээл тохиолдоно. Үүнийг үгүйсгэхгүй.

-Та өрсөлдөгчдөөсөө юугаараа ялгарч чадсан бэ?

-Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхдөө би намын дарга, Засгийн газрын сайд гэдэг утгаар бус, харин энгийн иргэний үүднээс оролцсон. Энэ миний давуу тал байсан болов уу.

-Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр юунд илүү ач холбогдол өгөв?

-Харамсалтай нь, Монгол Улс төрийн бодлогодоо үндэсний ашиг сонирхлыг харгалзан үздэггүй. Хүн амын хөгжил, шударга ёсыг хангахад төвлөрч ажиллах ёстой гэдэг асуудалд сонгогчдын анхаарлыг төвлөрүүлэхийг хичээсэн.

-Сонгуулийн кампанит ажлын үеэр таныг гайхшируулсан зүйл бий юү. Нууц биш бол сонирхолтой түүхээсээ бидэнтэй хуваалцаач?

-Та нар лав надад итгэхгүй байх. Гэхдээ би 12 өдрийн дотор Монгол Улсын 21 аймаг, гурван хотоор явж, сонгогчидтойгоо уулзсан. Машинаар Монгол орноо бүтэн тойрлоо.

-АНУ-ын Ерөнхийлөгч асан Барак Обамагийн хувьд зуун жилийн түүхтэй, их сургуулийн "Harvard Law Review" сэтгүүлийн ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх л маш хэцүү байсан гэж ярьдаг юм байна лээ. Таны хувьд хамгийн хэцүү, хүнд байсан сонгуулиа нэрлэхгүй юу?

-Тэгэлгүй яах вэ. Ерөнхийлөгчийн сонгууль хамгийн хэцүү хүнд байлаа. Учир нь Засгийн эрх барьж буй МАН бүх хэвлэл мэдээллийн хэрэгслийг атгаж байсан. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн 90 хувь нь миний өрсөлдөгчийн сурталчилгааг бүхэлд нь хийж байлаа. Иймээс ард түмэнтэйгээ хэвлэл мэдээллээр дамжуулж уулзах нь тун ховор байв. Мөн надтай хамтран ажилласан телевизийн лицензийг хураана гэж эрх барьж буй нам сүрдүүлсэн байсан. Гэхдээ би бууж өгөөгүй. Орчин үеийн технологи, ухаалаг утасны тусламжтайгаар сошиал медиаг ашиглан, Facebook live-аар сонгогчидтойгоо харилцаж эхэлсэн. Энэ нь зурагтаар сурталчилгаа хийхээс илүү үр дүнтэй байв. Үүнээс гадна, мэргэжлийн сумогийн 68 дахь их аварга Асашёорюү Д.Дагвадорж намайг дэмжсэн. Тэр Аса явуулын станц ажиллуулж, намайг дэмжсэн шүү.

-Өөрөөр хэлбэл, Трампын адил хүн бүр таныг таньдаг байсан хэрэг үү. Олон нийтийн анхаарлын төвд байх нь танд тус болсон хэрэг үү?

-Орчин үеийн технологи, ухаалаг утасны тусламжтайгаар олон нийтийн анхаарлын төвд байх нь их амархан.

-Монгол Улсыг та дахин агуу улс болгож чадна гэж боддог уу?

-Дахин сэргэн мандахын тулд бидний өвөг дээдсийн хүч чадал юунд оршиж байсныг эргэн санах хэрэгтэй. Агуу зорилгын төлөө монголчууд нэгдэж чадвал агуу улсыг бий болгож болно. Учир нь монголчууд Чингисийн удам шүү дээ. Би Оросын эрдэмтэн Лев Гумилевын онолыг эш татъя. Хэрвээ Монгол Улс өөрийн эдийн засгийн хараат бус байдлаа бэхжүүлэхийн тулд, мөн үйлдвэрлэгч орон болох нэг зорилгодоо хүрэхийн тулд ард түмнээ нэгтгэж чадвал агуу эзэнт гүрэн биш юм аа гэхэд бие даасан улсыг цогцлоох бүрэн боломжтой.

Монгол Улсын сул талыг давуу тал болгохын төлөө ажиллах болно

Бид баялаг, агуу түүх, уламжлалтай. Энэ нь шинэ эзэнт гүрэн бий болгоно гэсэн үг биш. Бид цаг үеэ дагаж хөгжих нь чухал. Би Монголоо ард түмэн нь аз жаргалтай, нийгэм нь хөгжингүй, эдийн засаг нь бие даасан улс байгаасай гэж хүсдэг. Бидэнд амьдралаа дээшлүүлэх хангалттай байгалийн баялаг, уламжлал, хариуцлагатай нийгэм байна.

Монгол Улс дэлхийн ноолуурын хэрэгцээний 30 хувийг үйлдвэрлэж байна. Гэхдээ энэ нь хангалттай гэсэн үг биш. Бид зэсийн нөөцөөрөө дэлхийд нөлөө үзүүлэх боломжтой. Мөн бид дэлхийд газрын ховор элемент, ураны зах зээлд идэвхтэй тоглогч болох бололцоо байна. Гэхдээ бидний өмнө тулгамдаж байгаа асуудал бол боловсруулах үйлдвэр.

Гажуудсан ардчиллаас үүдэлтэйгээр монголчууд олон жилийн үр дүнгүй улс төрийн намаас залхаж байна. Иргэдийн итгэл, найдвар алдарлаа. Шийдвэртэй, бодит үр дүнтэй бодлого үгүйлэгдэж байна.

-Сонгуулийн үеэр та гадаадын хөрөнгө оруулалт болон технологийг Монголдоо татах тухай ярьсан. Гадныг хөрөнгө оруулалтаас монголчууд их хувь хүртэх ёстой гэсэн хандлагын төлөө та тэмцэх үү. Монголчууд хэрхэн ашиг хүртэх ёстой вэ. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах ямар бодлогыг баримталж байна вэ?

-Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтад нээлттэй ханддаг. Бид гадаадын хөрөнгө оруулагчдад таатай нөхцөлийг бүрдүүлэхэд бэлэн байна. Өөрөөр хэлбэл, бид улс төрийн тогтвортой байдлыг хангах ёстой гэсэн үг. Хамгийн гол нь хоёр тал харилцан ашигтай хамтын ажиллагаа, шударга ёсыг эрхэмлэх ёстой. Энэ бол бидний зарчим. Ажлын байр бий болгож буй, монголчуудад үр өгөөжтэй, экспортод чиглэсэн хөрөнгө оруулалтыг би үргэлж дэмждэг. Гэхдээ би алт олборлолтын салбарт гадаадын хөрөнгө оруулагчид лиценз эзэмшихийн эсрэг зогсдог. Алт бол гадаад валютын нөөцийг илэрхийлэх, онцгой бүтээгдэхүүн гэдэг утгаар би энэ салбарт онцгой бодлого баримтална. Өөр сонголт бидэнд байхгүй.

-Та Владивостокт зохион байгуулагдсан "Дорнын эдийн засгийн чуулга"-д оролцсон. Чуулганы үеэр ямар хэлэлцээрүүдийг хийж чадав?

-Миний гадаад дахь анхны айлчлал Алс Дорнодоос эхэлсэн. Би "Дорнын эдийн засгийн чуулга"-д оролцлоо. Бидний нислэг Улаанбаатараас Владивосток хүртэл гурав хүрэхгүй цаг үргэлжилсэн. Энэ нь Алс Дорнод бол монголчуудын хувьд хол биш гэсэн үг юм. Энэ баримтад тулгуурлан миний бие энэ бүс нутагт хамтын ажиллагаа хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Би ОХУ, БНСУ-ын Төрийн тэргүүн болон Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэтэй хэлэлцээ хийсэн. Цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлэх маш их боломж бидэнд байгааг би олж харсан. Ерөнхийлөгч Владимир Путин үүнд чухал ач холбогдол өглөө. Тодруулбал, тэр илтгэлдээ миний хэлсэн үгэнд акцент өгч байсан.

-Ямар төслийг хөгжүүлэхийг сонирхож байна вэ?

-Монгол Улс далайд гарцгүй орон. Гэхдээ ашигт малтмалаар баялаг. Бид өөрсдийн бүтээгдэхүүнээ экспортлох зам хайж байна. Ази, Номхон далайн бүсийн улсын хувьд бид Приморский крайн Восточный боомтыг сонирхож байна. Энэ бол Монгол Улс далайд гарах гарц бөгөөд бүс нутгийн улс орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, дэлхийн зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулах боломж олдож байна гэсэн үг юм.

-Монгол, Оросын харилцааны хөгжлийн замд ямар саад тотгор байна гэж та харж байна вэ?

-Бидний хооронд түр хугацааны зөрчил байсан нь үнэн. Гэхдээ бид асуудлыг шийдэж чадна гэж бодож байна. 2014 онд Монгол, Оросын иргэд харилцан визгүй зорчдог болсон. Заримдаа хоёр тал тохиролцсон хэлэлцээрээ биелүүлэхгүй байгаа үед улс төрийн үл ойлголцол ажиглагддаг.

-Монгол Улс авторитар дэглэмтэй хоёр улсын дунд оршиж байна. Хэрхэн богино хугацаанд ардчиллын замыг сонгож чадсан бэ?

-ЗХУ задарсны дараа түүнд харьяалагдаж байсан улсууд ардчиллын замыг сонгосон. Гэхдээ Төв Азийн улсууд үүний гадна үлдсэн байдаг. Энэ нь бидний соёл, уламжлалын онцлогтой холбоотой гэж боддог. Монголчууд дүр төрхийн хувьд Ази. Гэхдээ бид Азийн бусад үндэстнээс ялгардаг. Европчуудаас мөн адил ялгардаг. Гэхдээ бидэнд европ соёл илүү давамгайлсан гэж боддог.

Агуу зорилгын төлөө монголчууд нэгдэж чадвал агуу улсыг бий болгож болно

-Монгол Улс газарзүйн ашигтай байрлалтай орон шүү дээ?

-Тийм ээ, бидний өвөг дээдэс урьдаас газарзүйн ашигтай байрлалыг тооцоолсон байх гэж боддог. Ялангуяа, бид хоёр том гүрний дунд оршиж байна. Энэ нь аюулгүй байдал талаасаа маш тааламжтай гэж хэлж болно. Иймээс бид өнөөдөр ардчиллын тухай нээлттэй, чөлөөтэй ярьж чадаж байна.

Үргэлжлэл бий... Forbes

Цаг үе

УРАН БҮТЭЭЛ

Б.Гэрэл: Аялан тоглолтоороо Өмнөговь, Дундговийн үзэгчиддээ оюуны бэлэг барина

П.Батбөх
ЗГМ



"Гэгээн МУЗА" 14 олон улсын театрын наадам энэ долоо хоногт эхэлсэн. Өнөө жилийн "Гэгээн Муза" наадам "Хүүхэд оролцооны бүтээл" болон "Драмын жүжгийн төрөл", "Хөгжимт жүжгийн төрөл", "Хүүхдийн жүжгийн төрөл", "Нэг хүний жүжгийн төрөл" гэсэн номинациар зохион байгуулагдаж буй. УДЭТ-ын хамт олон тус наадамд дөрвөн жүжгээр БНХАУ-ын ӨМӨЗО, АНУ, Аргентин, Украйн улсын уран бүтээлчидтэй өрсөлдөн ОХУ, Коссова, Хонконгийн зочин шүүгчдээр шалгуулах юм. Тодруулбал, УДЭТ-аас драмын жүжгийн төрлөөр "Адууны түүх", "Жаргаагүй нар", "Би эндээс явахгүй" зэрэг жүжиг нэр дэвшээд байгаа бол хүүхдийн жүжгийн төрөлд "Царцаа Намжил" жүжгийн уран бүтээлчид шилдэгт өрсөлдөхөөр нэрээ дэвшүүлээд байна. Үүнээс гадна тус театрын хамт олон орон нутаг дахь аялан тоглолтоо тун удахгүй хийхээр бэлтгэл ажлаа хангаад байгаа юм.

Орон нутаг дахь аялан тоглолтын талаар тус театрын маркетинг, төлөвлөлтийн албаны менежер, СТА Б.Гэрэлтэй ярилцлаа.

-Танай театраас орон нутгийн үзэгчдэд зориулан аялан тоглолт зохион байгуулдаг. Ойрын хугацаанд хаана аялан тоглолт хийхээр төлөвлөөд байгаа вэ?

-Манай театрын хувьд өөрийн тайзан дээр жүжгээ тоглохоос гадна хөдөө орон нутагт болон хот орчмын аялан тоглолт гэсэн хоёр чиглэлийг барьж жүжгүүдээ үзэгчдийн хүртээл болгодог уламжлал тогтсон. Орон нутгийн аялан тоглолтын тухайд манай театр дээхэн үед бригадаар явж, соёл үзвэрийн үйлчилгээ үзүүлдэг байсан. Нэг хэсэг тасраад байсан энэ уламжлалаа 2002 оноос сэргээсэн. 21 аймгаар хоёр удаа тойрон аялан тоглолтоо хийсэн байна. Аялан тоглолтууд маань төрөөс соёл урлагийн талаар баримталж буй бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн иргэдэд мэргэжлийн уран бүтээлээр хүрч үйлчлэх, төвийн болон орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор хийгдэж байгаа ажил.

-УДЭТ-аас бусад урлагийн мэргэжлийн байгууллага орон нутгийн үзэгчдэд хүрч ажиллаж чаддаггүй юм биш үү?

- Мэргэжлийн урлагийн ууган байгууллагын хувьд аймгуудын ЗДТГ, нийгмийн хөгжлийн хэлтэс, хөгжимт драмын театруудтай хамтран энэхүү ажлыг амжилттай зохион байгуулан орон нутгийн үзэгчдийн талархлыг хүлээсээр ирсэн. Бидний хувьд бусад мэргэжлийн урлагийн томоохон байгууллагууддаа үлгэрлэн, аялан тоглолт тасралтгүй явуулж ирсэн. Хэдийгээр манайх төсөвт орлого оруулдаг төрийн байгууллага хдий ч шилдэг бүтээлүүдийнхээ дээжээс орон нутгийн үзэгчдэд хүрч үйлчилье гэсэн зорилго давамгайлж жилдээ хоёр аймагт аялан тоглолтоор явж үйлчилдэг. Орон нутаг дахь тоглолтоо 50 хүртэл хувийн хөнгөлөлттэй үнээр үзүүлж оюуны бэлэг барьдаг. Өнгөрсөн жил намрын аялан тоглолтоо Архангай, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад амжилттай зохион байгуулсан. Тун удахгүй хаврын аялан тоглолтоо Дундговь, Өмнөговь аймагт хийхээр театрын урьдчилсан менежмент судалгааны баг бэлтгэл ажлуудаа хангаад ирлээ.



УДЭТ-ын архиваас©

-Эдгээр аймгаас гадна сумдад тоглох төлөвлөгөө байгаа юу?

- Хоёр аймагт тоглохоос гадна Өмнөговь аймгийн Ханбогд суманд "Саран хөхөө" жүжгээ тоглохоор болсон. Ханбогд суманд "Саран хөхөө" жүжгийг анх тоглож байсан туурь байдаг юм байна. Тиймээс 90 гаран жил тасраад байгаа энэ жүжгийг ирж тоглооч гэсэн хүсэлтийг нутгийнхан тавьсан. Манай театрынхан энэ сарын 16-нд Ханбогд суманд, 18-21-нд Даланзадгад хотод тоглохоор бэлтгэл ажлаа хангаад байна. Ханбогд сумын хүүхэд багачууддаа зориулан С.Михалковын "Бардам туулай" жүжгийг тоглоно. Ханбогд суманд "Саран хөхөө" жүжгийг тоглож байгаа бас нэг шалтгаан нь шинээр байгуулсан соёлын төвийнхөө нээлтийн хөшгийг энэ сайхан авшигтай жүжгээр нээе гэсэн хүсэлтийг манайд ирүүлсэнтэй холбоотой. Миний хувьд ч 2004 онд театрт менежерээр анх ороод "Саран хөхөө" хэмээх энэхүү сайхан бүтээлээр менежерийн ажлын гараагаа эхэлсэндээ бэлэгшээдэг. УГЗ, АЖ Б.Мөнхдоржийн найруулгаар тавигдсан үндэсний томоохон уг бүтээл 2004 оны "Гэгээн Муза" наадмын гранпри шагнал хүртэж байсан юм.

"Саран хөхөө" үндэсний туульсын жүжгийг анх тоглосон нутагт нь тоглоно

Ханбогд сумаас гадна Цогтцэций сумынхан маань манай нутгаар дайрахдаа сайхан бүтээлүүдээ тоглоод яваач гэсэн хүсэлт мөн өгөөд байгаа.

-Аялан тоглолтын хүрээнд Дундговь, Өмнөговь аймгийн төвд ямар жүжгүүд тавигдах вэ?

-Ханбогдод "Саран хөхөө" үндэсний туульсын жүжгээ тоглох далимаар Дундговь, Өмнөговь аймгийн үзэгчдийн хүртээл болгохоор төлөвлөөд байна. Түүнээс гадна манай театрын шинэхэн уран бүтээл болох Э.Оюуны "Би эндээс явахгүй" драмын жүжиг, Н.Ганхуягийн "Бүүвэй" уянгын драмын жүжиг, Нобелийн шагналт Дариа Фогийн "Чөлөөт хос" насанд хүрэгчдэд зориулсан хөгжимт инээдмийн жүжиг, С.Михалковын "Бардам туулай" зэрэг шинэ шилдэг бүтээлүүдээ толилуулхаар болсон.

-Алдартай ямар жүжигчид очих вэ. Алдартнуудтай зургаа авахуулах боломж олдох уу?

-Аялан тоглолтын бүрэлдэхүүнд театрын ахмад, дунд, залуу үеийн төлөөллийн жүжигчид болон арын албаны нийт 55 уран бүтээлчид багтана. Алдартай жүжигчдээс дурдвал Төрийн соёрхолт АЖ Н.Сувд, АЖ П.Цэрэндагва, Г.Мягмарнаран, С.Сарантуяа, УГЖ Б.Жаргалсайхан, Ж.Оюундарь гээд л манай бүхий л уран бүтээлч оролцох болно. Тэд маань орон нутгийн мэргэжил нэгтнүүддээ мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулахаас гадна үзэгчдэдээ тоглолтын дараах уулзалт ярилцлагууд хийнэ. Мөн алдартнуудын гарын үсгийг авч, дурсгалын зураг авахуулах боломж олгох зэрэг олон талт ажил төлөвлөгөөд байгаа.

Бас нэг зүйл онцлоход Өмнөговь аймгаас төрөн гарсан манай тайз, дэлгэцийн авьяаслаг жүжигчин Н.Цэвээнравдан гуайг өмнөговьчууд төдийгүй монголын ард түмэн андахгүй. "Говийн зэрэглээ", "Ингэх гээд байсан юм", "Би чамд хайртай", "Найрын ширээний ууц" зэрэг кино, Улсын хүүхэлдэйн театр, УДЭТ-ын олон жүжигт дүр бүтээсэн Монголын алдарт жүжигчин Н.Цэвээнравдан агсны отгон хүү Ц.Төгсбилэгт аавынхаа мэргэжлийг өвлөн 2015 оноос манай театрт ажиллаж байгаа. Өмнөговьчуудын хувьд ч гэсэн алдартай жүжигчнийх нь хүү авьяасыг нь өвлөн нутаг орондоо очин эдгээр бүтээл тоглох нь бахархалтай явдал.

-Орон нутгийн соёлын орднуудад мэргэжлийн том жүжиг тоглоход тайз, хэрэгсэл хэр шаардлага хангадаг юм бэ?

-Орон нутгийн соёлын орднуудын тайз, дикроцид бүтээлүүдээ тохируулан тоглодог. Үүний тулд тэндхийн тайзны нарийн хэмжээг авч дахин үйлдвэрлэл явуулах зорилгоор жүжиг чимэглэлийн эрхлэгч гэсэн мэргэжлийн ажилтнаа судалгааны багтаа аваад явсан. Мэргэжлийн, жүжигчин чанараа алдахгүйн тулд мэдээж эндээсээ гэрэл, техник хэрэгсэл, дуу шум, хувцас хэрэглэлээ авч явдаг.

Төгсгөлд нь хэлэхэд орон нутгийн аялан тоглолтыг дэмжин ажиллаж байгаа аймаг Сумдын ЗДТГ, НХХэлтэс, Театрт чуулгууд болон оюунлаг үзэгчдээдээ талархлаа илэрхийлье. Тун удахгүй театрын шилдэг бүтээлүүдээр уулзацгаая.

-Баярлалаа. [ЗГМ]

ЭРҮҮЛ МЭНД

Б.Доржмаа: Сэтгэцийн өвчин удамшдаг байсан бол одоо стрессээс үүсдэг болсон

Дүүргийн эмнэлэгт мэргэжлийн сэтгэлзүйч үнэ төлбөргүй ажилладаг

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн сэтгэц, наркологийн донтолтын эмч, анагаах ухааны магистр, клиникийн профессор Б.Доржмаатай цаг үеийн асуудлаар ярилцлаа.

-БЗД бол хүн ам ихээр төвлөрсөн том дүүрэг. Дүүргийн хэмжээнд сэтгэл зүйн үнэгүй зөвлөгөө өгч ажиллаж байгаа нь олзуурхууштай. Харин иргэд танай эмнэлгийг хэр их мэдэж үйлчлүүлдэг вэ?

-Мэдээж Баянзүрх Улаанбаатар хотын хамгийн том дүүргийн нэг. Ойролцоогоор 300 мянган хүн амтай. Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвд сэтгэц, наркологийн баг иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа. Манай багт мэргэжлийн сэтгэцийн эмч хоёр мэргэшсэн сэтгэлзүйч сувилагч тус бүр нэг бий. Манайх үнэ төлбөргүй үйлчилдэг. Бусад нарийн мэргэжлийн эмч нараас ялгаатай нь урьдчилж цаг авалгүйгээр үйлчүүлж болдог. Хандаж байгаа иргэн бүрт хүрч үйлчлэх зорилготой. Хоёр эмчийн нэг нь сэтгэц, нөгөө нь донтолтоор дагнаад ажиллаж байна.

Мэдээж хүн амын тоогоо дагаад ачаалал өндөр. Ялангуяа, сэтгэцийн эмгэгийн улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүс мэргэжлийн эмчийн хяналтад байдаг. Үүнээс гадна шинэ өвчлөл нэмэгдсээр байгаа. Үүнд сэтгэцийн өвчтэй хүмүүс байна, мөн сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хүмүүс ч бий.

Гэхдээ манай сэтгэлзүйчид хандаж буй иргэдийн тоо харьцангуй бага. Уг нь энэ олон хүн амд сэтгэл зүйн зөвлөгөө авах шаардлагатай хүн олон байгаа нь тодорхой. Гэвч сэтгэл зүйн эмч дээр ирж үзүүлбэл хүмүүс намайг мэдрэл муутай болчихож гэж бодно, Шархадны эмнэлэгт очиж хэвтэх хүмүүс л энд ирдэг гэсэн ойлголт түгээмэл. Тухайн хүний сэтгэл санаа тавгүйтсэн, стресстэй болсон байна, сэтгэцийн эмчид үзүүл гэвэл хүмүүсийг манайх руу явуулдаг. Гэвч ихэвчлэн ууртай, дургүй л орж ирдэг. "Би яахаараа энд ирэх ёстой юм, би эрүүл хүн, танайд галзуу солиотой хүмүүс л ирэх ёстой биз дээ" гэж харьцана.

Хүнд сэтгэцийн ямар ч асуудал тулгарч болно, мөн энэ байдлаас гарах боломжтой гэдгийг бид тайлбарлаж, ойлгуулаад явуулдаг. Ер нь дүүргийн эмнэлэгт мэргэшсэн сэтгэлзүйчид үнэ төлбөргүй ажилладаг гэсэн мэдээлэл иргэдийн дунд бага байх шиг байна.



-Сэтгэцийн үйлчилгээ авах нь барууны өндөр хөгжилтэй оронд бол том соёл. Энэ соёлыг л илүү дэлгэрүүлмээр санагдлаа.

-Яах аргагүй тийм. Хүмүүс хамгийн гол нь зөвөөр хүлээн авч, хэрэгцээ гэдгийг ойлгох хэрэгтэй. Өөрт тулгамдаж буй асуудлыг ойлгохгүй, түүнийгээ даван туулах чадваргүй үед л тухайн хүнд маш том асуудал үүсдэг. Гэр бүлийн дунд үл ойлголцол гарна, салж сарниж байна. Мэргэжлийн сэтгэлзүйчээс зөвлөгөө авах нь энэ бүх хүндрэлийг даван туулахад хэрэгтэй гэдгийг л иргэдэд ойлгуулмаар байна.

-Яг энэ чиглэлээр боловсон хүчин хэр бэлтгэгдэж байна вэ?

-Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшдэг хүмүүс харьцангуй бага шүү. Бас л галзуу солиотой хүмүүстэй харьцана гэсэн ойлголттой. Харин бусад дүүргийг бодвол манайх мэргэшсэн сувилагчтай. Миний бодлоор энэ мэргэжлийг л хүмүүст зөв таниулмаар байгаа юм. Эмэгтэйчүүд гоо сайхны үйлчилгээ байнга авч, хэрэгцээ шигээ ойлгочихсон байдаг. Тэгсэн хэрнээ өөрийнхөө сэтгэл зүрхийг ойлгох, сэтгэл санааны тулгамдсан асуудлаа бусадтай нээн хуваалцах тал дээр хойрго ханддаг. Нэг бол ийм үйлчилгээ байдгийг мэддэггүй юм уу, эсвэл сэтгэц, наркологи гэсэн нэрэнд нь болоод байдаг юм шиг санагддаг.

-Энэ мэргэжлийн онцлог юу бол?

-Сэтгэцийн эмч, сувилагчийн мэргэжлийг үнэхээр сонирхсон, сэтгэл зүрхээ зориулна гэсэн хүмүүс л сонгож байгаа. Гэхдээ нөхцөл байдал, цалин хангамж хэцүү л дээ. Жишээ, нь би 23 жил ажиллаж байгаа хэрнээ 630 мянган төгрөгийн үндсэн цалинтай. Татвар, суутгалаа хасаад 500 гаруй мянган төгрөг л гар дээрээ авч байна. Гэтэл энэ ажил хэвийн бус, эрсдэлтэй гэж явдаг. Яагаад гэвэл бид өдөр тутамдаа сэтгэцийн хувьд хэвийн бус хүмүүстэй ажилладаг. Сэтгэцийн эмч нар ажлын байран дээрээ халдлагад өртөж, амиа алдсан тохиолдол ч бий.

Хэдийгээр ийм хэцүү ч гэсэн нэгэнт сонгосон хүмүүс мэргэжлээсээ буцдаггүй. Хэрэв энэ мэргэжлийг зөв ойлгуулж, хэрэгцээг нь таниулвал хүмүүст маш их хэрэгтэй.

Манай мэргэжлийн сайхан тал их бий. Ялангуяа, хүмүүст тус болж, тодорхой үр дүнд хүрснийг харах сайхан байдаг. Би өмнө нь донтолтын чиглэлээр түлхүү ажиллаж байсан. Хамгийн сүүлд архинаас татгалзаад 10 жил боллоо гээд нэг залуу ороод ирсэн. Би өөрөө мартчихаж. Гэтэл намайг энд байгааг мэдээд зорьж ирээд талархлаа илэрхийлж байсан. Энэ бүгдээс урам авч байгаа юм. Ер нь сэтгэцийн хувьд тайвшраад, үр нөлөөгөө үзүүлсэн бол хүмүүс орж ирээд талархаад гардаг юм.

-Удахгүй сувилагч нарын өдөр тохиох гэж байна. Танай сувилагчдын ажил хэр хүнд вэ?

-Сүүлийн үед сэтгэцийн мэргэшсэн сувилагч маш цөөрсөн. Ихэнх нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дээр ажиллаж байна. Мэргэшсэн сувилагч бол сэтгэцийн өвчлөлтэй хүнтэй яаж харьцах, ямар асаргаа сувилгаа хийх, гэр бүлийнхэнд нь ямар мэдээлэл зөвлөгөө өгөх вэ гээд бүх зүйлд суралцсан байдаг. Маш өндөр мэдлэг, мэдрэмжтэй байх ёстой. Яагаад гэвэл сэтгэцийн өвчин гэдэг хүний мэргэжил, нас хүйс, боловсрол харгалзахгүй үүсч байгаа шүү дээ. Тэгэхээр ямар түвшний хүн орж ирнэ, түүнд нь тохируулж харилцах ёстой. Харин манай сувилагч үүнийг сонирхоод, мэргэшээд ирсэнд маш их баяртай байдаг.

-Та нар янз бүрийн хүмүүстэй харьцаж байна. Өмнөхтэй харьцуулахад хүмүүсийн сэтгэл зүйд ямар өөрчлөлт гарсан бол. Ер нь сэтгэцийн эмгэгтэй хүмүүс нэмэгдэж байна уу?

-Сэтгэцийн өвчин нийгмийн байдлыг дагаад нэмэгдэж байгаа. 1990-ээд оны үед бидэнд замын түгжрэл, утааны асуудал байсангүй. Тэр үед сэтгэцийн өвчин илүү удамшиж илэрдэг байв. Гэтэл одоо стресстэй холбоотой үүсч буй эмгэг нэмэгдсэн. Сэтгэл гутрал, нойргүйдэл, хүүхэд ахуй насандаа авсан сэтгэцийн эмгэгтэй хүмүүс илүү хандаж байгаа. Мөн сүүлийн үед донтолт улам нэмэгдэж байгаа нь яах аргагүй анхаарах асуудал болчихоод байна.

-Ярилцсанд баярлалаа. [ЗГМ]

ZGM DAILY

Minister of Mining visits Aduunchuluut coal mine

Aduunchuluun JSC is facing license dispute with MAK LLC over 134 hectares of area.

Standing Committee on Justice discusses nominees of IAAC head

The committee members disapprove President's proposal over violation of laws.

Buman-Olz LLC discovers rare earth elements in its Khuut mine

The company plans to increase its capacity and explore 7-10 million tons of coal per year.

35 civil societies present a letter of demand to the CEO of OT

Head of working group responsible for re-viewing OT agreement temporarily dismissed.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Prime Minister Khurelsukh Ukhnaa is on a working visit to Uvurkhangai, Bayankhongor and Gobi-Altai aimags on May 7-10, aiming to hold meetings with local administrations and citizens, get au fait with socio-economic situations and operations of hospitals, schools and SMEs, as well as to resolve pressing issues.

Director of the Financial Regulatory Commission of Mongolia Davaasuren Sodnomdarjaa attends the 43rd Annual Conference of the International Organization of Securities Commission taking place in Budapest between May 7 and 11.

Mongolia-Russia Initiative 2018 to be held in Ulaanbaatar on June 7-10 with an aim to expand and develop multilateral relations of Mongolia and Russia Parliament's Standing Committee on Security and Foreign Policy convenes and decides to ratify the International Seed Treaty.

ECONOMY

Financial Regulatory Commission approves Mongol Bazalt LLC as a closed public company and registers its 56,417,000 shares.

Innovation Partnership – Development Gateway 2018 forum takes place.

Top 20 Index falls 0.18 percent, 19595.45 points. MSE A Index decreases 0.21 percent, to 9530.06 points and MSE B Index increases 0.18 percent, to 9896.69 points. Market cap stands at MNT 2.44 trillion.

SOCIETY

Innovation Week is taking place in Mongolia until May 13.

Meteorologists warn sudden cold and precipitations.

Mongolian national rugby team to compete in the Division 3 Central of the Asia Rugby Championship in Almaty, Kazakhstan, on May 16-19.

Mongolian young athletes participates in the 8th Rocket Science Sports Long Course Swim Competition, which took place in Shanghai, China, wining one gold, two silver and two bronze medals.

Aduunchuluun's license conflict to be resolved



ZGM©

Area coincided with MAK LLC has a coal reserve of 40-50 million tons

Tugsbilig.B
@tugsbiligZGM

During his official trip in local areas in Dornod and Sukhbaatar aimags, Minister of Mining and Heavy Industry Sumiyabazar Dolgorsuren visited the Aduunchuluun JSC's coal mine, which has been continuously supplying the Eastern Region Energy Systems JSC (ERES) with thermal coal for 63 years. Since establishment, Aduunchuluun has run open-pit and underground mining operations, removing 28.4 million cubic meters of topsoil and produced 14.9 million tons of coal. In addition to ERES, it also provides its products to companies, organizations and households in Dornod aimag. As of 2017, the company allocated MNT 1.16 billion to the state budget.

According to the Mining Minister, Aduunchuluun, which was privatized in 1999, is facing a serious issue of concurrent licenses in its mining areas. Specifically, 134 hectares of area was concurrent with MAK LLC's mining license granted in 2009. Currently, MAK LLC possesses two licenses on 5104.3 hectares and is conducting topsoil removal on the area. Accordingly, Aduunchuluun was unable to run any operation on its area due to the license dispute. If the issue is settled, the company will have an opportunity to run operation for the next 30-40 years. The coincided area has a resource of 40-50 million tons of coal.

The CEO of Aduunchuluun JSC told the minister that the company is has no area left to mine. The ERES in Dornod has no coal reserves and is in a difficult situation of energy shortage. He was grateful that the delegation had an in-situ visit during the company's time of difficulty.

The company's management requested the Mineral Resources and Petroleum Authority of Mongolia to urgently issue its relevant decision based on the Clauses 62.4, 62.5 and 62.6 of the Minerals Law of Mongolia. Mr. Sumiyabazar told the management to submit its request and documents related to the license, and highlighted that there will be no risk of energy irregularity in the area. [ZGM]

POLITICS

President's proposal faces opposition

On Tuesday, Parliamentary Standing Committee on Justice discussed the President of Mongolia's proposal of candidates for the head and deputy head of the Independent Authority Against Corruption. The majority of the committee members disapproved the proposal on the ground that it has violated several laws.

Primarily, the proposal was submitted on Friday to the Parliament. On Monday, the Mongolian People's Party group in Parliament discussed the proposal at its closed meeting and reached a position not to support the candidates proposed by the President. The MPP group considers that the appointment term of the present heads have not been expired.


Oil refinery feasibility is being audited

The feasibility study of an oil refinery in Dornogobi aimag is currently being audited. According to an initial estimate, the oil refinery which is being financed by India's USD 1 billion fund, is expected to produce 1.5 million tons of oil per year.

The plant is expected to produce 560 thousand tons of Euro-4/5 gasoline, 670 thousand tons of diesel fuel, and 107 thousand tons of liquefied gas. However, these numbers could be changed after the detailed feasibility study.

Altanshiree soum was selected for its closer location to the infrastructure that gives the opportunity to transport crude oil from Dornogobi's 19th and 21st site.

Minister of Mining and Heavy Industry Sumiyabazar Dolgorsuren said that the construction work of the oil refinery will begin by the third quarter of this year and will be commissioned in 2022. [ZGM]



MINING

Lithium and rare earth elements discovered in Khuut mine

On May 6, a delegation led by Minister of Mining and Heavy Industry Sumiyabazar Dolgorsuren got an au fait with the Khuut mine in Matad soum of Dornod aimag.

Last year, Buman-Olz LLC explored 126.1 thousand tons of coal and exported 93.8 thousand tons of coal to the People's Republic of China and supplied the remaining to the domestic market.

Tsogtjargal Dondovdorj, CEO of Buman-Olz LLC, noted that the company has just discovered rare earth elements including lithium reserve in its mining site and expressed their interest to intensify the exploration. He also said, "We are supporting the initiative of re-planning the Matad Soum, which is situated 40 kilometers from our mining site. We will comply with any decision made by the Government".

Minister of Mining and Heavy Industry Sumiyabazar Dolgorsuren noted that there are ample opportunities to develop Matad as a model soum.

According to the 32nd resolution of the Parliament, the state policy on railway transport was approved in 2010. During the trilateral meeting between the Presidents of Mongolia, Russia and China in Uzbekistan in 2016, a program on establishing the economic corridor between the three countries was approved and the parties agreed to study the economic opportunities to implement the Eastern Railway Corridor project included in the appendix of the program.

The authorities of Buman-Olz LLC mentioned that the 234 kilometer and 34 kilometer railway projects connecting Khuut with Bichigt would have a great impact on local development by reducing unemployment and improving creativity of the people in the area. Currently, Buman-Olz LLC employs more than 130 domestic workers. The company has a plan to increase its capacity and explore 7-10 million tons of coal per year.

Since 2009, the company has begun removing soil and coal extraction at the Khuut mine which has 11.1 million tons of coal resources. [ZGM]

Civil societies demand to nationalize 51 percent of Oyu Tolgoi



Khasui.B / ZGM©

Yesterday, 35 civil society organizations headed by the National People's Movement for Rescuing the Country non-government organization presented a letter of demand to nationalize the 51 percent stake of Oyu Tolgoi to Armando Torres, CEO of Oyu Tolgoi.

In the letter of demand, it was warned of not conducting talks and signing agreement on the underground development as the open-pit mine, which is being mined until today has no returns to Mongolian people, and demanded to immediately stop its illegal action of hindering the working group, which was established under a decree issued by the Parliament Speaker for the purpose of inspecting and examining OT's operations, and reviewing the Investment Agreement of OT. The letter also demanded the OT to run its operations in accordance with Mongolia's laws and regulations.

"In addition, there is a demand for cancellation of the agreement or amend it by including a clause under which Mongolian citizens shall own the 51 percent and make other related clauses to be clear and transparent," the letter emphasized.

"In the clause 6.1 of the Constitution of Mongolia and in the 1803rd resolution of the UN issued in 1962, the state of the wealth and resources shall receive majority of their wealth and resources," Head of the Board of Directors of the National Movement Erdenebayar Aviermed underscored.

"Under the regulations of the shareholders' agreement, Mongolia has to pay USD 3 million, which equals the cost of constructing 5 kindergartens, per day for settling the debt," he added.

On Monday, MP and Chairman of Parliamentary Standing Committee on Economy Damba-Ochir Dorjdamba, former head of the abovementioned working group, submitted a letter of temporary dismissal from the head of the working group. On that day, the MPP group in the parliament discussed the request and appointed MP Terbishdagva Dendev as the head of the working group. [ZGM]

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР

MNB

07.00 "Өглөө" хөтөлбөр /шууд/

09.00 Тэд эх орныхоо төлөө тулалдсан юм" УСК 1-р анги

11.00 "Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр

14.00 "Тулалдаанд зөвхөн хашрууд ниснэ" УСК

20.00 "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөр

21.10 "Нээлттэй хором" ток шоу /шууд/

Bloomberg TV Mongolia

07.00 Танилц: Япон нэвтрүүлэг

09.00 Бизнесийн хэмнэл Мэдээний хөтөлбөр

11.00 #Made in Mongolia Баримтат нэвтрүүлэг

14.30 Хариуцлага ба үнэ цэнэ нэвтрүүлэг

21.00 Мөнгөний урсгал Мэдээний хөтөлбөр

22.30 Ногоон хот нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ HD

08.00 "4 өнгө" цаг агаарын хөтөлбөр

11.20 Үүнийг хэрхэн хийдэг вэ?

13.00 "Жонон" хамтлагийн тоглолт 1-р хэсэг

19.00 "Төгс бэр" ОАК 43-р анги

20.40 "Монголын алтан дуу хоолойтнууд" тоглолт 1-р хэсэг

00.45 "Монголчууд XX зууны эхэнд" нэвтрүүлэг

МОНГОЛ ТВ

06.30 Өнөө өглөө хөтөлбөр

10.30 "Хуурамч хэрэг" СОАК 15-р анги


12.00 Хөтөч мэдээллийн хөтөлбөр

19.00 "Мөрдөгч хүүхдүүд" ОАК /season-2/ 51, 52-р анги

20.00 Оргил цаг мэдээллийн хөтөлбөр

22.30 "Empire" ОАК /season-3/ 14 дүгээр анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 24
Хаврын адаг, улаан луу сарын гурван хөх мэнгэтэй, цагаагчин үхэр өдөр.
Үс засуулбал: Өвчин эмгэг ирнэ
Наран ургах, шингэх: 05.25-20.14
Барилдлага: Идэр
Шүтэн барилдлага: Хурьцахуй
Суудал: Шороо

Аргын тооллын тавдугаар сарын 9, Буд гараг. Билгийн тооллын 24. Чөдөр одтой, цагаагчин үхэр өдөр.
Өдрийн наран 05.25 цагт мандан, 20.14 цагт жаргана. Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лус тахих, мал арилжих, буг дарах, газрын ам бооход сайн. Цөөрөм байгуулах, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



"Game Symphony" концерт
Хэзээ: 2018.05.10-ны 19.00 цагт
Хаана: СТӨ
Тасалбарын үнэ: ₮40-45 мянга



"Царцаа намжил" хүүхдийн жүжиг
Хэзээ: 2018.15.12-ны 12.00 цагт
Хаана: УДЭТ
Тасалбарын үнэ: ₮ 8000



"The best of"хүндэтгэлийн тоглолт
Хаана: Соёлын төв өргөө
Хэзээ: 2018.05.09-ний 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 30 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР

ОХУ-ын Чита хотын Драмын театрынхан Монголд




УДЭТ-ын тайзнаа энэ сарын 9, 10-нд ОХУ-ын Чита хотын Драмын театрын уран бүтээлчид хүүхдийн болон инээдмийн мюзикл жүжгээ толилуулах гэж байна.
78 жилийн түүхтэй уг театрыг ОХУ-ын СГЗ Ю.И.Пояркин 2016 оноос удирдаж байгаа бөгөөд уран сайхны удирдагч, залуу найруулагч Н.Гадомскийн хамт гадаад харилцаагаа улам өргөжүүлэн тэлэх, олон улсад уран бүтээлээ танилцуулах зорилго тавин ажиллаж байна.
Энэ удаагийн айлчлан тоглолт үүний нэгэн илэрхийлэл юм.
УДЭТ-т тоглогдох гэж буй "Русский секрет" буюу "Оросын гайхамшиг" жүжиг нь Оросын зохиолч Н.С.Лесковын 1881 онд бичсэн "Левша" буюу "Солгой" хэмээх туужаас сэдэвлэн орчин үеийн мюзикл хэлбэрээр хийсэн бүтээл ажээ. Энэ зохиол нь Орос дарханы ур чадварыг гаргадаг.
Бяцхан монгол үзэгчдэд зориулсан "Аладдины шидэт дэнлүү", 12-оос дээш насныханд зориулсан "Оросын гайхамшиг" жүжгүүдийг орос хэл дээр тоглогдож байгаа нь оюутан сурагчдад хэлний мэдлэгээ тэлэх ховорхон боломж олгож байна. [ЗГМ]



"Аида" дуурь
Хэзээ: 2018.05.12-ны 17.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-30 мянга




"Би эндээс явахгүй" жүжиг
Хэзээ: 2018.05.12-ны 18.00 цагт
Хаана: УДЭТ
Тасалбарын үнэ: ₮10-25 мянга



"Төрөл авалт" орчин үеийн бүжиг
Хэзээ: 2018.05.10-ний 18.30 цагт
Хаана: The Corporate & Convention Center
Тасалбарын үнэ: ₮20 мянга

ЗГМ: УГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
1. Алтан ургийн эцэг Бодончирийн эцэг ... мэргэн
2. Германы нутгаар урсдаг мөрөн гол
3. Титаник киноны хит дууг дуулсан Канадын алдарт дуучин
4. Мал амьтны арьсанд үрждэг, хэдгэнийн авгалдай
5. Хүн амьтны гэрлэн бүрхэвч
7. Баруун Украины гэгддэг улс
8. Италын хөлбөмбөгийн алдартай баг
10. Италийн алдартай машин
11. Наасан юм
12. Дэлхийн нэгэн чухал давхарга
13. Нохойны чухал чанар
14. Хөлийн улны хойд хэсэг
15. Цаатны гэр
16. Монголд гоёл, ёслолд хэрэглэгддэг суудлын тэрэг
17. Үзэсгэлэнт цэцэг
18. Халуун орны мод

ХӨНДЛӨНГӨӨР:
1. Монгол Улсын XX зууны манлай уртын дуучин
6. ОХУ-ын сансрын туршилтын талбай (Казахстан хот)

Өмнөх дугаарын хариу / 05.08

				Б				А				
		Е	С	Ө	Н	Б	У	Л	А	Г		
		В		М		А		Ч		О		
Я	В	А		Б		Я	Х	И	Р		Ө	Ш
Р			Ц	Ө	Ө	Н		Б		Б		О
Г	А			Г		М		Э		А	З	И
У		Б	Ө	Ө	Р	Ө	Н	Х	И	Й		Г
И	Н	У		Р		Н		И		Г	У	У
		И				Х				А		
		Р	У	Н	И		А	Р	А	Л		

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

	V.09	V.10	V.11	V.12	V.13
	20° / 1°	24° / 8°	10° / 6°	14° / -2°	22° / 2°
	8 м/с / 6 м/с	11 м/с / 8 м/с	12 м/с / 12 м/с	10 м/с / 7 м/с	9 м/с / 6 м/с
	Багавтар үүлтэй	Үүлшинэ	Бага зэргийн бороотой	Багавтар үүлтэй	Багавтар үүлтэй




ФОТО АГШИН



Эр өссөн ч ижийдээ нялхаараа

Б.Хасуй /ЗГМ©

ЗГМ: СУДОКУ

3	2	7						
			8			1	7	
		1	7	6				
1					4	9	5	
					8			1
4	3			9	6	7		
	9	2		4			3	6
							9	4
		6		3		5		

3	6	7	8	9	5	1	2	4
8	2	9	1	6	4	5	7	3
5	1	4	7	2	3	8	9	6
4	9	2	3	7	8	6	1	5
7	5	6	9	4	1	3	8	2
1	8	3	6	5	2	9	4	7
2	4	8	5	1	6	7	3	9
9	3	5	4	8	7	2	6	1
6	7	1	2	3	9	4	5	8

(Өмнөх дугаарын хариу)

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

МОСКВА-УБ	21.35	07.30
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	06.10	08.25
УБ-ХАНБУМБАТ	07.20	08.30
УБ-ТОКИО	07.45	13.40
УБ-СӨҮЛ	08.20	12.30
ХАНБУМБАТ-УБ	09.20	10.25
БЭЭЖИН-УБ	09.30	12.00
СӨҮЛ-УБ	14.20	17.00
ТОКИО-УБ	14.40	19.15
УБ-ХАНБУМБАТ	20.00	21.10
ХАНБУМБАТ-УБ	22.00	23.05

ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

Жанцан овогтой Шаравын 1998 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр олгогдсон 7676 тоот Цагаатгалын үнэмлэхийг үрэгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Comcast компани Walt Disney-Fox гэрээнд саад болохоор зэхэж байна

АНУ-ын банкуудаас 60 тэрбум ам.долларын санхүүжилт босгож эхэллээ. > 10

Nestle-гийн глобал амбиц өргөжлөө

Шинэ хэлцэл нь Nestle-гийн "түүхэн сул тал"-ыг засах боломж хэмээн удирдлага нь үзэж байна. > 10

Европ дахь дизель машины борлуулалтаа аажмаар зогсооно

Nissan дизель хөнгөн тэрэгний үйлдвэрлэлээ зогсоож, дизель хөдөлгүүрийг ачааны машинуудад үлдээнэ. > 10



ВВМ©

Владимир Путин ОХУ-ын Ерөнхийлөгчийн тангараг өргөхөөр Кремлийн их танхимд орж ирж байгаа нь.

Путин эдийн засгийн том зорилт дэвшүүллээ

◀1

Орос орон хүн амын өсөлтөө тогтвортой хадгалах, үйлдвэрлэлийн бүтээмж, технологийн инновацийг хурдацтай өсгөх шаардлагатай хэмээн тэрбээр тайлбарлаж байна.

Ноён Путиний төлөвлөгөө нь Орос оронд айл өрхийн бодит орлого багасаж, хөрөнгө оруулалт буурсан нь нийгмийн тогтворгүй байдал үүсэх эрсдэлтэйг Кремль ухамсарлаж буйг харуулав.

"Зарлиг нийгмийн зардлыг өсгөх олон амлалтад тулгуурлажээ. Тэгсэн мөртөө шүүх засаглалын тогтолцоог өөрчлөх, өмчийн эрхийг хамгаалах, эдийн засагт төрийн оролцоог бууруулах зэрэг хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад амин чухал заалт огт алга" хэмээн брокерын BCS компанийн эдийн засагч Владимир Тихомиров шүүмжиллээ. "Бодитой ажил хэрэгч хөтөлбөр биш, улс төрийн популист тунхаг болж" хэмээн тэрбээр онцлов.

Даваа гарагт Кремлийн ордны алтадмал гурван танхимд цугласан 5000 зочны өмнө ноён Путин Оросын ард түмний төлөө зүтгэж, иргэдийн эрх, эрх чөлөө, улс орны бүрэн эрхт байдлыг хамгаалах тангараг өргөлөө.

Нийтээр таамаглаж байсанчлан ноён Путин эртний хамтрагч Дмитрий Медведевийг Ерөнхий сайдаар нэр заасан юм. Түүний сонголтыг ОХУ-ын парламентын доод танхим-Төрийн Дум мягмар гарагт батална.

Ноён Путиний итгэмжит хүн, либерал эдийн засгийн шинэчлэлийг сахин хамгаалагч, Сангийн сайд Антон Силуанов албан тушаалдаа хэвээр үлдэхийн зэрэгцээ Ерөнхий сайдын орлогчоор ажиллана гэдгийг ноён Медведев мэдэгдлээ. Уг томилгоотой уялдан ноён Путиний эдийн засгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг ноён Силуанов голлон хариуцах болж байна.

Ноён Путиний нийгмийн зардлыг өсгөх амлалтыг юугаар санхүүжүүлэх вэ гэдэг ганц асуултыг ажиглагч нар тавилаа.

"Холбооны төсвийн нэмэлт орлогыг улсын цар хүрээтэй хөтөлбөр хэрэгжүүлэхэд ахиу хуваарилах"-ыг даваа гарагт гаргасан зарлигаар Засгийн газарт үүрэг болгожээ. Чухам энэ заалт ОХУ-ын санхүүгийн шинэ зохицуулалттай харшилж байгаа. Учир нь газрын тос, шатдаг хийн үнийн тодорхой хязгаарааас давсан орлогыг Улсын нөөцийн санд (ОХУ-ын баялгийн сан) оруулах ёстой.

Шинэ Засгийн газар газрын тосны үнийн босгыг 42 ам.доллараас 50 орчимд өсгөж, үүсэх зөрүүг нь нийгмийн зардалд хуваарилах нэг арга байж болохыг шинжээч нар тайлбарлав. "Газрын тосны үнэ баррел нь 75 ам.доллар болчхоод байгаа одоогийн нөхцөлд зөв арга" хэмээн ноён Тихомиров өгүүлэж байна.

Ноён Путиний эдийн засгийн зөвлөх, Ерөнхийлөгчийн эдийн засгийн шинэчлэлийн стратегийг боловсруулахад оролцсон Алексей Кудрин ч мөн ижил бодолтой байна.

Ноён Кудриний дэвшүүлсэн гол санал санаачилга багтаагүй Ерөнхийлөгчийн зарлиг урам хугалсан зүйл болж байгааг ОХУ-ын аж үйлдвэрийн группийн дээд албаны нэгэн эрхэм тайлбарлав. "Хөрөнгө оруулалт татах шалтгаан болж чадах татварын шинэчлэл, тэтгэврийн насыг нэмэгдүүлэх гэх мэт бусад олон асуудлын талаар юу ч дурдсангүй" хэмээн тэрбээр шүүмжиллээ. Бүтцийн шинэчлэл өрнөх найдлага ноён Путинтэй хамт үлдэх багийн бүрэлдэхүүнээс шалтгаална хэмээн шинжээчид үзэж байна. "Кудрин хаа очихыг харах хэрэгтэй. Хэрвээ энэ хүн кабинетэд юм уу Ерөнхийлөгчийн захиргаанд дээд албанд үлдвэл өөрчлөлт өрнөх найдвар бий" гэцгээв. Ноён Путин гуравдугаар сарын Ерөнхийлөгчийн сонгуульд 76 гаруй хувийн саналаар ялсан нь хуучин ЗХУ-ын үеэс хойших удирдагчдын алинд ч байгаагүй үнэмлэхүй амжилт болсон юм. Сонгуулийн дүн нь дайчилгаа маягийн зохион байгуулалттай аяны үр дүн болохоос иргэдийн үнэнхүү дэмжлэгийг тусгасан хэрэг биш хэмээн улс төрийн зарим шинжээч үзэж байна.

FT

Эдийн засгийн удаашрал хувьцааны зах зээлд нөлөөлөхгүй



Карен Уард

АНУ-ын хувьцааны зах зээл нэгдүгээр сарын сүүлээр дээд цэгтээ хүрсэн. Энэ нь үнэт цаасны цаашдын хандлага үндсээрээ өөрчлөгдөх магадлалтай гэх асуулт үүсгээд буй. Энэ оны эхний хэдэн долоо хоногт дэлхийн эдийн засгийн огцом өсөлт, дэлхийн мөнгөний сул бодлоготой холбоотойгоор хувьцааны зах зээлд эерэг хандлага ажиглагдан хурдацтай сайжирлаа. 2018 он гарангуут гурван долоо хоногийн дотор S&P 500 долоон хувиар өсөж, MSCI Europe гурван хувиар чангарсан бол Японы Topix мөн гурван хувиар нэмэгдсэн.

Гэвч үүнээс үүдэн бизнесийн итгэл сулраад буй. Эдийн засгийн өндөр өсөлтийг дагаад огцом уналт үүсэж, зах зээлийг хөдөлгөж буй хүч сулрах вий гэсэн айдас үүсээд буй.

Хэрэв АНУ-ын Холбооны нөөц эдийн засгийн өсөлтөөр дамжуулж ханшийг хэвийн хэмжээнд аваачихаар шийдвэл орлогын цаашдын төлөв сайжирч, үнэт цаасны үнэд эерэгээр нөлөөлнө. Гэхдээ сүүлийн саруудад бизнесийн итгэлийг ганхуулаад буй өсөлтийн удаашрал хөрөнгө оруулагчдыг АНУ-ын төв банкны хүүгээ өсгөх чармайлтыг анхаарахаас аргагүй нөхцөл үүсгэлээ.

Энэхүү ганхалт Европт илүү харагдаж буй. Удаан хүлээгдсэн эдийн засгийн сэргэлтийн дараа бизнесүүд өнгөрсөн гуравдугаар сард бага зэргийн уналтад орсон. Үүнээс үүдэн хөрөнгө оруулагчдад эдийн засгийн сул үзүүлэлт түр зуурынх уу эсвэл цаашид үргэлжлэх уналт уу гэх эргэлзээ төрүүлж байна.

Цаг агаарын байдал ч мөн уг үзүүлэлтэд нөлөөлсөн. Хоёр-дугаар сарын 24-нөөс эхлэн Их Британи, Ирландаар дайран өнгөрсөн агаарын хүйтний урсгал өнгөрсөн сарын сүүлээр намдсан. Үүнээс үүдэн Их Британийн зах зээл зогсонги болоод зогсохгүй Испани хүртэлх умард зүгийн орнуудын бизнест сөргөөр нөлөөлсөн аж.

Гэхдээ уг тивийг хамарсан эдийн засгийн уналтын гол шалтгаан нь ам.долларын эсрэг евро огцом суларч, 1.26 ам.долларт хүрсэнтэй холбоотой ба цаашид 1.3 ам.доллар хүрнэ гэх таамаг байгаа аж. Түүнчлэн хөрөнгө оруулагчид худалдааны дайнаас эмээж эхэлсэнтэй холбоотой төдийгүй Евро бүсийн экспортлогчдын хэтийн төлөв таарууxан харагдсаар буй. Үүнтэй ижил дүр зураг 2011 болон 2016 оны эхэн үеэр ажиглагдаж, бизнесүүд уналтад орж байв.

Нөгөөтэйгүүр, экспортлогчдод ээрэг дүр зураг ажиглагдаж эхэллээ. Европын төв банк өөрсдийн хэт сул бодлогод тэвчээр, тэсвэр шаардлагатайг тодорхойлж, үүнийг дагаад евро бага зэрэг чангаран 1.20 шүргэлээ.

Худалдааны дайны айдас ч мөн адил намжих төлөвтэй байна. БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жиньпин гаднын бизнест томоохон саад болдог Хятадын оюуны өмчийн хязгаарлалтын талаар АНУ-тай хэлэлцэх сонирхолтойгоо илэрхийлсэн. Хэрэв хэлэлцээрээр Хятадын зах зээлд нэвтрэх саадыг бууруулж чадвал АНУ-ын компаниуд гэлтгүй дэлхийн бүх компанид эерэгээр нөлөөлнө.

Иймээс үүсээд буй бага зэргийн айдас дэлхийн эдийн засгийн өсөлтөд тийм ч ноцтой нөлөөлөхгүй дүр зураг ажиглагдаж байна.

FT


Иран дахь Трампын бодлого АНУ-ын газрын тосны үнийг өсгөв

Грегори Мэеэр, Эд Крүүкс, Сем Флеминг


Цагаан ордон Ираны цөмийн гэрээнээс гарах эсэх мэдэгдэл хийснээс АНУ-ын газрын тосны үнэ сүүлийн гурван жилд анх удаагаа 70 ам.долларыг давлаа.

АНУ-ын газрын тосны бенчмарк West Texas Intermediate-ийн үнэ энэ даваа гарагт 70.84 ам.долларт хүрч, 1.6 хувиар нэмэгдсэн нь 2014 оны 11 дүгээр сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт юм. Хойд Тэнгисийн Brent ч мөн адил 3.6 жилийн дээд цэгтээ хүрч, 76 ам.доллар гараад буй.

Brent газрын тосны үнэ
(Баррель ам.доллар)



WTI газрын тосны үнэ
(Баррель ам.доллар)



АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп даваа гарагт жиргэж, Цагаан ордон мягмар гарагт Ираны гэрээтэй холбоотой мэдэгдэл гаргах болсныг мэдэгдсэн. Трамп өдийг хүртэл ээлж дараалан Иран, АНУ болон түүний түншүүдийн хоорондох гэрээг шүүмжилсээр ирсэн. Хэрэв тэрбээр Иранд дахин хориг тавибал тус улсын газрын тосны экспорт буурах нь гарцаагүй ба цаашлаад олон улсын зах зээлд савлагаа үүсгэх магадлалтай юм.

Өнгөрсөн хугацаанд дэлхийн улс орнууд Ираны цөмийн зэвсгийн хөтөлбөрийн эсрэг хоригоо сулруулсантай холбоотойгоор тус улсын газрын тосны нийлүүлэлт өдөрт дөрвөн сая баррель болон нэмэгдэж байсан. Тэгвэл дахин хориг тавибал Ираны газрын тосны экспорт өдөрт 200-300 мянган баррелиар буурна хэмээн RBC Capital Markets таамаглаж байна. АНУ-ын шатахуун түгээгүүрийн нэг галлон түлшний дундаж жижиглэнгийн үнэ 2.85 ам.доллар байгаа ба өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад тав дахин өндөр аж. АНУ-д төвтэй хөрөнгө зохицуулагч Pimco газрын тосны үнийн өсөлт инфляцыг хөөрөгдүүлж, АНУ-ын эдийн засагт саад учруулна хэмээн шүүмжилж байна.

FT

Syndicated articles from
FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Comcast компани Walt Disney-Fox гэрээнд саад болохоор зэхэж байна



АНУ-ын кабелын компани 60 тэрбум ам.долларын санал тавихаар хэлэлцээ эхлүүллээ.

ВВМ©

Жеймс Фонтанелла-Хан

Comcast компанийн стратегитай танилцсан эх сурвалжийн мэдээлж буйгаар тус компани Walt Disney-гийн 21st Century Fox-ийн бизнес, олон улсын хөрөнгийг 52 тэрбум ам.доллараар худалдан авах гэрээнд саад болох гэж байна. Тиймээс АНУ-ын банкуудаас 60 тэрбум ам.долларын санхүүжилт босгож эхэллээ.

Энэхүү хэрэг явдал нь АНУ-ын шүүх AT&T компанийн Time Warner-ийг 108 тэрбум ам.доллараар худалдан авах ажиллагааг зөвшөөрсөнтэй холбоотой юм. Эх сурвалжуудын мэдээлж буйгаар уг худалдан авах ажиллагаанд АНУ-ын Хууль зүйн газар саад хийхээр оролдож буй аж.

Comcast-ийн гүйцэтгэх захирал Брайн Робертс Fox компанийн хөрөнгийг шууд бэлэн мөнгөөр худалдан авах санал боловсруулж эхэлжээ. Энэ нь Fox-ийн үүсгэн байгуулагч Рюперт Мурдокийн Sky-ийн 61 хувийг худалдан авах болсонтой холбоотой. Учир нь уг 61 хувийг худалдан авбал Европын хэвлэлийн компанийн эзэмшил бүхэлдээ Мурдокийн гарт очих юм.

Comcast компани Fox-ийн эзэмшлийн бус 61 хувийн нэгж хувьцааг 12.5 фунтээр худалдан авах санал тавьж, уг телевизийн группийг 22 тэрбум ам.доллараар үнэлсэн. Энэ нь Мурдокийн санал болгосноос бараг дөрвөн тэрбум ам.доллараар өндөр санал юм.

Харин Walt Disney компани Fox-ийн эзэмшдэг Sky-ийн 39 хувийн хамт тус компанийн хөрөнгийг худалдан авахаар өнгөрсөн 12 дугаар сард тохиролцжээ. Тухайн үед Comcast илүү өндөр дүнтэй санал тавьсан ч АНУ-ын хууль зохицуулагчдаас зөвшөөрөл авах магадлал бага тул Мурдок саналаасаа татгалзсан юм. Ингэснээр Мурдок Disney-тэй тохиролцож, Fox-ийг 13.7 тэрбум ам.долларын нийт өрийн хамт зарахаар болов.

Сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн салбарын гэрээ хэлэлцээрүүд ихсэх болсон нь уламжлалт тоглогч Netflix, Amazon, Apple зэрэг шинэ үеийн хөрөнгөтэй дижитал компаниудын өсөн нэмэгдэж буй өрсөлдөөнтэй нүүр тулсантай холбоотой юм.

Харин АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Comcast-ийг салгана хэмээн заналхийлээд буй. Тус компани Universal Studios, NBC broadcast network зэрэг томоохон бизнесийг өөртөө нэгтгэсэн NBC Universal-ийг эзэмшдэг бөгөөд Трамп уг компанийг АНУ-ын телевиз үзэгчид дунд хэт их хүчтэй хэмээн шүүмжилдэг. Трамп NBC Universal-ийг Comcast-аас хэрхэн салгах нь тодорхойгүй байгаа ч боломжгүй биш юм.

AT&T-ийн Time Warner-ийг худалдан авах ажиллагаа мөн ижил төрлийн асуудалтай тулгарч байна. Гэсэн хэдий ч шинжээчид АНУ-ын Хууль зүйн газрын хүсэлтээр шүүгчид уг худалдан авах ажиллагаанд саад хийх магадлал тун бага гэсэн байр суурьтай байна.

Хэрэв AT&T шүүхэд ялбал Comcast-д Fox-ийн хөрөнгийг амжилттай гартаа оруулахад нь маш том туслалцаа болно. Fox-ийн хөрөнгө дунд 21 th Century Fox-ийн кино студи болон хэд хэдэн телевизийн суваг багтаж байгаа. Харин Fox News Мурдок гэр бүлийн удирдлага дор хэвээр үлдэнэ. Энэхүү мэдээлэлд Comcast хариулт өгөөгүй хэмээн Reutrers мэдээлж байна. FT



Бизнес хэлцэл Швейцарын группийг өрсөлдөгчөөс нь хол давуу болгож, Starbucks-ын дэлхийд тэлэх төлөвлөгөөнд түлхэц өглөө.

ВВМ©

Nestle-гийн глобал амбиц өргөжлөө

Шехеразаде Данешку, Ральф Эткинс

Nestle компани кофе шопын сүлжээ Starbucks-тай хийсэн 7.15 тэрбум ам.долларын хэлцээгээ даваа гарагт зарласан нь Швейцарын компанийн сул болон давуу талыг харууллаа. Nestle хүнс, ундааны үйлдвэрлэлээр дэлхийн хамгийн том компани төдийгүй кофены зах зээлд ч ноёрхдог. Кофе, creamer буюу сүү, цөцгий орлуулагчийн наймаа Nestle-д жилд 17 тэрбум ам.долларын орлого оруулдаг нь нийт худалдаа эргэлтийн 20 хувийг бүрдүүлж байна. Түгээлтийн тогтолцоо, мэргэжлийн дадлага туршлагынхаа ачаар Starbucks-ын чухал түнш болсон Nestle-д гурван том бэрхшээл бий.

Юун түрүүнд, Германы тэрбумтан Рейманы хүүхдүүдийн хөрөнгийг эрхлэн хөтөлдөг хувийн хөрөнгө оруулалтын JAB Holdings групп кофены ертөнцөд өргөжин тэлэх зорилго тавьсан нь Nestle-гийн зах зээлд заналхийлэх болов.

Хоёрдугаарт, JAB дэлхийн кофены гол хэрэглэгч АНУ-ын зах зээлд тавхан хувь эзэлдэг байр сууриа ихэсгэх зорилгоор 2012 оноос хойш Keurig Green Mountain, Krispy Kreme, Peet's Coffee зэрэг олон компанийг өөртөө нэгтгэхэд 30 тэрбум ам.доллар зарцуулласан. Тус компани мөн Mondelez International-тэй хамтран Jacobs Douwe Egberts-ийн кофены бизнесийг өөрийнх болгосон.

Гуравдугаарт, Nestle нь уусдаг кофе болон кофены машинд хийх зориулалттай капсулын үйлдвэрлэлд төвлөрдөг. Савлагаа бүхий хайрч, шарж нунтагласан кофены зах зээлд тус компанийн эзэлдэг байр суурь сул.

Nestle эдгээр гурван чиглэлээр давшихад Starbucks-тай байгуулсан хэлцэл тус болно. Уг хэлцэл нь 2017 оны нэгдүгээр сараас хойш Nestle-гийн гүйцэтгэх захирлаар ажиллаж буй Марк Шнайдерын хамгийн зоримог арга хэмжээ болж байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр уг хэлцэл нь Nestle-гийн нэгтгэх, худалдан авах ажиллагаанд гуравдугаарт орж байгааг Bernstein-ы шинжээч Эндрю Вуд тайлбарлав. Ноён Шнайдер Nestle-г хэрэглэгчдийн эрүүлийг хамгаалах салбарт нэвтрүүлэх сонирхолтой. Тус компани Германы эм үйлдвэрлэгч Merck-ийн хэрэглэгчийн эрүүлийг хамгаалах бизнесийг, эс бөгөөс АНУ-ын Pfizer-ын хэрэглэгчийн салбарыг худалдан авч болзошгүй хэмээн шинжээчид таамаглаж байна.

Гэхдээ л Nestle бизнестээ кофег эн тэргүүнд тавьдаг. Starbucks-тай байгуулсан хэлцэл нь Nestle-гийн "Умард Америк дахь бизнесийн түүхэн сул талыг нь засах боломж" хэмээн Швейцарын компанийн удирдлагын нэг мэдэгдсэн юм.

Түншлэлийн хэлцлийн дагуу Nestle-д Starbucks-ын 500 ажилтан шилжинэ. Nestle АНУ-ын компанитай шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэхэд хамтран ажиллаж, Starbucks-ын капсулыг кофены машиндаа ашиглана. АНУ-ын групп Nestle дэх өөрийн брэндийн менежментийг хариуцах бөгөөд Starbucks-ын уухад бэлэн кофены бизнес хэлцэлд хамаарахгүй.

Швейцарын компани гол нь АНУ-ын группыг бага байр суурьтай бусад зах зээлд илүүтэй нэвтрэхдээ Starbucks-ын бүтээгдэхүүнийг ашиглах сонирхолтой байгаа. Жишээ нь, уусдаг кофе илүү түгээмэл хөгжиж буй зах зээлд Starbucks-ын уусдаг кофе борлуулах юм.

"Бид 28 улсад савласан бүтээгдэхүүнээ борлуулдаг. Тэгвэл Nestle бараг 190 улсад ажилладаг тул бидэнд байхгүй бизнесийн цар хүрээтэй" хэмээн Starbucks-ын олон улсын бизнесийн тэргүүн Жон Калвер тайлбарлав. "Starbucks нь хилийн чанадад хэрэглээний савласан бүтээгдэхүүнээ борлуулахад ахиц муутай явж ирсэн. Nestle-тэй байгуулсан хэлцэл нь АНУ-ын компани хилийн чанадад тэлэхэд тус болох нь дамжиггүй" хэмээн Susquehanna-ын шинжээч Пабло Зуаник үзэж байна. FT

Европ дахь дизель машины борлуулалтаа аажмаар зогсооно

Питер Кэмпбел

Nissan Европт дизель хөдөлгүүрт загвар борлуулахаа аажим зогсоохоо мэдэгдлээ. Энэ нь шатахууны бохир эх үүсвэрээс салж буй авто үйлдвэрлэгчдийн сүүлийн шинэ жишээ болов.

Японы тус үйлдвэрлэгч 2021 оноос дизель хөдөлгүүрт хөнгөн тэрэгний үйлдвэрлэлээ зогсоож, их даацын ачааны болон зорчигч тээврийн машинуудаа дизель хөдөлгүүрийн сонголттой үлдээнэ. Toyota компани Европ тивд дизель дизель машинуудыг бүгдийг, гибрид машинуудын ихэнхийг хориглохоор төлөвлөж байна.

Nissan компани "Манай цахилгаанжуулах хүчин чармайлт эрчимжиж буй тул одоогийн загваруудыг шинэчлэх хугацаа болмогц дизель хөдөлгүүрээ шат дараатай хална. Гибрид машин шинээр гаргах, дан цахилгаан хөдөлгүүрт машины төрөл загвар олшрох хэрээр шилжилт улам хурдасна" хэмээн мэдэгдэв. Европ тивд дизель хөдөлгүүртэй



хөдөлгүүрт машин борлуулахаа зогсоох гэж байгаагаа хэдийнэ зарласан. Мөн Fiat Chrysler зургадугаар сард мэдэгдсэн төлөвлөгөөнийхөө дагуу 2022 он гэхэд бүх хөнгөн тэргэндээ дизель хөдөлгүүр тавихаа зогсооно.

Засгийн газрууд цагтаа Европ тивийн автомашинуудад ноёлж байсан шатахууны хэрэглээг хязгаарлаж эхэлсэнээс дизель хөдөлгүүрт загварын борлуулалт эрчимтэй унаж буй үед Nissan-ийн мэдэгдлээ. Франц 2040 оноос дизель төдийгүй бензин хөдөлгүүртэй автомашин борлуулахыг бүрэн хориглоно. Тэгвэл Германы зарим хот хуучны дизель хөдөлгүүрт машинуудыг хэдийнэ хорихложээ. Дизель хөдөлгүүрт машины татварыг өсгөсөн.Их Британийн Засгийн газар 2040 оноос бензин, автомашины борлуулалт өнгөрсөн онд найман хувиар буурч, шатахууны зах зээлийн 43.8 хувийг эзэлдэг болсныг Jato Dynamics-ын судалгаа харуулж байна. Бууралт 2018 оны эхний саруудад бүр хурдсаж, ялангуяа Их Британид энэ оны эхний дөрвөн сард дизель машины борлуулалт даруй 32 хувиар багаслаа.

Дизель хөдөлгүүрт машины борлуулалт багассантай уялдан Их Британийн Сандерлэнд дэх үйлдвэрийнхээ олон зуун ажлын байрыг хасах шийдвэр гаргахаас аргагүй болсноо Nissan өнгөрсөн сард мэдэгдсэн. Дизель хөдөлгүүр нь бензин хөдөлгүүртэй харьцуулахад нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт 20 хувиар бага. Иймч учраас машины хорт утааны ялгарлыг 2021 он гэхэд хатуу хязгаарлах Европын холбооны чанд шаардлагад дизель хөдөлгүүр илүү нийцнэ хэмээн саяхан болтол автомашин үйлдвэрлэгч компаниуд үзэж байлаа. Уг нөхцөл өөрчлөгдсөний улмаас дизель хөдөлгүүрт машины борлуулалт буурсан нь авто үйлдвэрлэгчид их хэмжээний торгуулиас зайлсхийж, цахилгаан болон гибрид машин үйлдвэрлэхэд түлхэц өгөв.

Nissan компанийг Renault, Mitsubishi-тэй байгуулсан холбооны хүрээнд тооцох нөхцөлд хөнгөн тэрэгний дэлхийн хамгийн том үйлдвэрлэгч болдог. Тус компанийн дан цахилгаан хөдөлгүүрт Leaf загвар борлуулалтаараа Европ тивд хэдийнэ аварга амжилт тогтоогоод байгаа юм. Карлос Гоны удирдлага дор ажилладаг уг гурван авто үйлдвэрлэгч 2022 он гэхэд дан цахилгаан хөдөлгүүр бүхий 12 загвар гаргах төлөвлөгөөтэй. Nissan компани 2025 он гэхэд Европ тивд борлуулдаг машиныхаа тэн хагасыг цахилгаан болон гибрид болгох зорилт тавьжээ.

Nissan компани дизель хөдөлгүүрийг "ачаа тээврийн зориулалттай бага оврын машинуудад одоо ч чухал" хэмээн тайлбарлаж байна. FT

Эдийн засаг

Компанийн үнэлгээнд талууд санал нэгдэхэд хугацаа их шаарддаг

"IPO Conference 2018" хямд санхүүжилт татах сайн туршлагыг хуваалцана

З.Цэлмэг
@tselmegZGM

Эдийн засаг сэргэж, хөрөнгийн зах зээлд хөл хөдөлгөөн орж байгаа энэ цаг үед хувьцаа гарган хямд санхүүжилт босгохоор сонирхож буй компаниудад зориулсан IPO Conference энэ сарын 30-нд болно. Энэ талаар санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Mongolia International Capital Corporation ХХК –ийн судалгаа хариуцсан дэд ерөнхийлөгч Б.Зулбаяртай ярилцлаа.

-IPO Conference 2018 ямар зорилготой арга хэмжээ вэ?

-Эдийн засаг сайжирч, компаниуд хувьцаа гарган хямд санхүүжилт босгох сонирхол нэмэгдэж байна. Иймээс MICC компани МҮХАҮТ-тай хамтран хувьцаа болон хямд санхүүжилт босгох сонирхол бүхий Танхимын гишүүн байгууллагуудад зориулан IPO Conference 2018 хурал зохион байгуулах гэж байна. Хуралд оролцоноор аж ахуйн нэгжүүд хямд санхүүжилт хэрхэн олох, санхүүжилт татах үе шат болон зайлшгүй хангах нөхцөл шаардлагуудын талаар санхүүгийн зөвлөх, аудит, үнэлгээ, хуулийн болон үнэлгээний компаниудаас мэргэжлийн зөвлөгөө, мэдээллийг нэг дороос авах юм. Уг хурлаар эдгээр амжилттай босгосон санхүүжилтийг гардан гүйцэтгэсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, зохицуулах болон дэмжих чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагууд өөрсдийн ажил үйлчилгээний талаар мэдээлэл хүргэнэ.

Тухайлбал, хуулийн фирм гэхэд хувьцаа нийтэд санал болгоход тавигдах хуулийн шаардлагууд, бэлтгэл үе шатны талаар танилцуулах бол аудитын фирм компанийн үнэлгээ болон аудитын шаардлагын талаар танилцуулах юм. Энэ арга хэмжээ хямд санхүүжилт татах сонирхолтой бүхий л компанид нээлттэй.

-Хөрөнгийн зах зээлийн идэвжилд нөлөөлсөн шалтгаануудыг юу вэ?

-Хөрөнгийн зах зээл гэдэг нь товчхондоо хуримтлалаа аривжуулах гэсэн хөрөнгө оруулагч болон хямд санхүүжилтийн эх үүсвэрээр бизнесийн зардлаа бууруулан ашгаа нэмэгдүүлэхийг зорьж буй компаниудын уулзах газар. Монголын санхүүгийн зах зээлийн 95 хувийг банкны салбар эзэлдэг боловч хөрөнгийн зах зээл, даатгал гэх мэт санхүүгийн бусад салбар эрчимтэй хөгжиж, хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэж байна. Үүнд нөлөөлж байгаа хэд хэдэн хүчин зүйлс байгаа. Тухайлбал, өнгөрсөн гурав дөрвөн жилүүдтэй харьцуулахад 2017 онд хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын тараасан ногдол ашгийн хэмжээ эрс нэмэгдэж, бараг 70 тэрбум төгрөгт хүрсэн. Мөн хадгаламжийн хүүгээс 10 хувийн татвар авч эхэлсэн нь иргэд, аж ахуйн нэгжүүдийг банкны хадгаламж гэхээсээ илүү хөрөнгийн зах зээлд оролцох сонирхол нэмэгдэхэд нөлөөлж байгаа байх.

Мөн гадаадын хөрөнгө оруулагчдад ногдох ногдол ашгийн татварыг 20 хувиас 5 хувь хүртэл бууруулахаар татварын шинэчилсэн хуулийн төсөлд тусгасан нь гадаадын хөрөнгө оруулагчдыг Монголын хөрөнгийн зах зээлд оролцож, хөрөнгө оруулахыг дэмжсэн Засгийн газрын нэг алхам гэж ойлгож байгаа. Одоогоор Монголын үнэт цаасны арилжаанд оролцогчдын ердөө дөрвөн хувь нь гадаадын хөрөнгө оруулагчид байна.

-Ямар төрлийн компаниудад хөрөнгийн зах зээлд гарах боломж илүү байна вэ?

-Бизнес төлөвлөгөө нь ойлгомжтой, тодорхой төсөлтэй, мөнгөн урсгалтай, хүлээн зөвшөөрөгдсөн чадварлаг удирдлагын багтай, мөн компанийн засаглалаа сайжруулахаар чармайн ажиллаж байгаа компаниуд хөрөнгийн зах зээл дээрээс амжилттай хөрөнгө татах боломжтой.



ЗГМ©

Их бага гэлтгүй ногдол ашиг тогтмол тараадаг болоход анхаарах ёстой

Хамгийн гол нь хувьцаагаа нийтэд санал болгож байгаа одоогийн хувьцаа эзэмшигчид нь цаашид аудит болон зохицуулах чиг үүрэг бүхий байгуулагуудтай нягт хамтран ажиллаж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироохгүй ажиллах ёстойг ухамсарлах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, зохих ёсоор үйл ажиллагаагаа тогтмол тайлагнах, хувьцаа эзэмшигчид болон бусад талуудын ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр компанийн засаглалыг хэрэгжүүлж ажилладаг байхыг хэлж байгаа гэсэн үг.

-Том компаниуд энэ зах зээлийг сонирхдоггүй шалтгаан нь юу вэ?

-МҮХАҮТ-аас жил бүр эрэмбэлдэг Монголын ТОП 100 аж ахуйн нэгжээс арав хүрэхгүй компани нь Хөрөнгийн бирж дээр гарсан нээлттэй компаниуд. Гэтэл дэлхийд алдартай Fortune500 жагсаалтад байдаг компани нээлттэй буюу нийтэд хувьцаагаа санал болгосон байх жишээтэй. Монголын томоохон компаниуд хувьцаагаа нийтэд санал болгохгүй байгаа шалтгаан нь янз бүр байх. Зарим нь нийтэд санал болгох компаниудад тавигддаг зохих шалгууруудыг хангадаггүй, бизнесийн зохих түүхтэй учир өөрсдөө хямд санхүүжилт олох боломжтой, эсвэл нээлттэй компани болсноор тогтмол аудит болон хөндлөнгийн төрөл бүрийн хяналт тавигддаг. Ингэснээр үүнтэй холбоотой зардлууд нэмэгдэнэ гэж үзээд татгалздаг. Эсвэл хувьцаагаа гаргаж компанийн өмчлөлд өөрчлөлт оруулвал бизнесийн шийдвэр гаргахад нийт хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөл шаардагддаг, улмаар бизнесийн шийдвэр гаргах үйл явцыг удаашруулдаг гэж үздэг гэх мэт шалтгаанууд бий.

-Та шинжээч хүний хувьд дүгнэхэд компаниуд хөрөнгийн зах зээлд гарахад ихэвчлэн ямар сорилттой тулгардаг вэ?

-Монголын компаниуд хөрөнгийн зах зээлд гарахад нийтлэг ажиглагддаг бэрхшээл нь компанийн үнэлгээний асуудал юм. Компаниа нийтэд санал болгож байгаа хувьцаа эзэмшигчид үнэлгээ, ашиг орлогыг өөдрөгөөр харж, өндрөөр үнэлэх сонирхолтой, нөгөө талаас хөрөнгө оруулагчид компанийн зах зээл дэх байр суурь болон бизнесийн ашиг орлого, хөрөнгийг маш няхуур шалгаж хөрөнгө оруулалт хийх эсэхээ шийддэг. Иймээс үнэлгээний тал дээр талууд нэг байр суурьтай болохын тулд хугацаа шаардах тал бий. Мөн дотоодын компаниуд хувьцаагаа нийтэд санал болгохдоо нийт хувьцааны бага хэсгийг олон нийтэд санал болгодог. Ингэснээр компанийн үйл ажиллагаанд жижиг хувьцаа эзэмшигчдийн дуу хоолой байхгүй байх, эрх ашиг нь хохирох явдал түгээмэл ажиглагддаг. Иймд компаниуд нийтэд хувьцаа санал болгохдоо жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл компанийн шийдвэр гаргах механизм буюу Төлөөлөн удирдах зөвлөлд байхаар тооцож хувьцаагаа санал болговол хөрөнгийг зах зээлээс санхүүжилт татна гэж бодож байна. Одоогоор хөрөнгийн биржид хувьцаагаа гаргасан компаниудын ихэнх нь арав хүрэхгүй хувиа гаргасан байдаг нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх, улмаар хөрөнгө оруулагчдын Монголын хөрөнгийн зах зээлд оролцох сонирхлыг бууруулж байна.

-Үүнийг даван туулахад компаниуд хэр зэрэг чадавхтай байна вэ?

-Компаниуд их бага гэлтгүй ногдол ашиг тогтмол тараадаг болоход анхаарах ёстой. Одоогоор Монголын үнэт цаасны зах зээлд 300 гаруй хувьцаат компани байгаа ч ердөө арав хүрэхгүй хувь нь ногдол ашиг тараж байна. Мөн улирлын, хагас жилийн болон жилийн санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд нь тогтмол нийтэд танилцуулдаг болоход анхаарахгүй бол одоогоор энэ үзүүлэлт тун хангалтгүй байгаа. Үүнд, сүүлийн жилүүдэд зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд анхаарал хандуулж, шаардаж эхэлснээр тодорхой ахиц гарч байгаа нь сайшаалтай. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

1.6

Сая. Монголын хөрөнгийн биржийн арилжаагаар 21 компанийн 1.6 сая хувьцаа арилжсанаас 11 компанийн хувьцааны ханш өсөж, наймынх нь буурав.

» АРИЛЖАА

14

Хувь. "Авто Зам" компанийн хувьцааны ханш 14 хувиар өссөн бол "Евроазиа Капитал Холдинг"-ийнх 9.9 хувиар дээшилжээ.

» ТАТВАР

Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд явагдсан олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төсөлд хамгийн их буюу 2142 санал, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 1349 санал хүлээн авсныг Сангийн яамнаас мэдээлэв.

» ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

7.6

Тэрбум ам.доллар. АНУ-ын хөрөнгө оруулалтын Blackstone компани үл хөдлөх хөрөнгийн Gramercy Property Trust-ийг 7.6 тэрбум ам.доллараар худалдаж авахаар болов. Gramercy Property Trust-ийн хувьцааг хаалтын ханшнаас 15.4 хувиар өндөр үнээр, 100 хувь бэлэн мөнгөөр авахаар тохиролцжээ.

» ТҮҮХИЙ ЭД

0.1

Хувь. West Texas төрлийн газрын тосны ханш 0.1 хувиар өсөж, 69.8 ам.долларт хүрлээ.

» УУЛ УУРХАЙ

1314


Ам.доллар. Алтны ханш олон улсын зах зээлд тогтвортой буюу 1314 ам.доллартай тэнцэж байна.

УУЛ УУРХАЙ

Нүүрстэй"-д 54 өрөмдлөг хийнэ

Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Aspire Mining компани Хөвсгөл аймгийн нутагт байрлах "Нүүрстэй" төсөлдөө анхаарч байна.

Энэ ордын талбайд 2018 онд 54 өрөмдлөг хийх төлөвлөгөөгөө Ашигт малтмал, газрын тосны газраар батлуулсан ба ойрын хугацаанд ажлаа эхлэхээр төлөвлөж буй аж. "Нүүрстэй" төсөлтэй ойр байрлах ордоос 100 мянган тонн нүүрс худалдаж авахаар Төрийн өмчит PSST компани гэрээ байгуулжээ. Энэ нүүрсийг одоо байгаа төмөр замаар тээвэрлэн БНХАУ, ОХУ, БНСУ, Японы зах зээлд экспортолж, "Нүүрстэй" төслийн ТЭЗҮ-д ашиглах зорилгоор тээвэр логистик, өртөг зардлыг нь тооцох төлөвлөгөөтэй байгаа аж. Aspire Mining компани "Нүүрстэй" төслөөс гадна "Эрдэнэт-Овоот" чиглэлийн 547 км урт төмөр зам барихаар зорьж байна. Төмөр замын барилгын ажлын хүрээнд China Gezhouba Group-тэй хамтран ажиллахаар болжээ.





ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,402.94
Евро	2,861.18
Японы иен	22.05
ОХУ-ын рубль	38.13
БНХАУ-ын юань	377.37
БНСУ-ын вон	2.23

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018.05.09-ний өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:
ГАШУУНСУХАЙТ АВТОЗАМЫН ТҮР ЗОГСООЛ БАРИХ АЖИЛ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:
ЭМГЛ/201802019

"Эрдэнэс Монгол" ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Гашуунсухайт автозамын түр зогсоол барих ажлыг гүйцэтгэх тухай** битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) үнэ төлбөргүйгээр татан авах боломжтой бөгөөд тендерт оролцохын тулд эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50'000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон ажлын туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017он/-ийн борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс доошгүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас доошгүй байна.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017/.

Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2015, 2016, 2017 оны аль нэг жилд нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас доошгүй үнийн дүнтэй ижил төстэй ажилд үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм.

ЗТХЯ-наас олгодог:

2.8.6 Хатуу болон хайрган хучилттай зам засварлах,

2.8.8 Зам, замын байгууламжид хамаарах талбайх барих, засварлах.

Тендерт оролцогч нь тендерийн хамт захиалагчийн төсөвт өртгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөг (эсхүл түүнтэй тэнцүү үнийн дүнгээс доошгүй төлөөтэй хөрвөх валют)-ийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем **(www.tender.gov.mn)**-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр **2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 30 минутаас** өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 40 минут**-д нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх "эрхгүй".
Дотоодын давуу эрх "тооцохгүй".

"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК
УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, 1-Р ХОРОО, ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ-15, МОННИС ЦАМХАГ, 14-Р ДАВХАР. УТАС: 75553399-249

Эдийн засаг

Гаднынхан тоодоггүй салбарт дотоодын компаниуд тоглолт хийдэг



Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрт өнгөрсөн онд 2.4 тэрбум төгрөг орон нутгийн төсөвт төвлөрчээ. Энэ нь 2016 онтой харьцуулахад 300 орчим сая төгрөгөөр өссөн үзүүлэлт болж байна.

С.Батсайхан / ЗГМ©

Түгээмэл тархацтай ашигт малтмалыг дотоодын компаниуд олборлож байна

◀1

Гэвч техник технологийн шаардлага хангаагүй, нөхөн сэргээлт хийлгүй орхигдсон талбай даамжирсан тул шинээр тусгай зөвшөөрөл олгохоос аль болох төр зайлсхийж эхэлсэн. Ялангуяа, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль гарсан цагаас хойш буюу сүүлийн дөрвөн жилийн хугацаанд тус салбар дахь зохицуулалт ялимгүй сэргэж, цэгцэрч байгаа. Хэдий тийм ч тусгай зөвшөөрлөө бусдад худалдах, дамлан зарах, татвар, хураамжаас зугтах байдал амь бөх оршсон байгаа юм.

Олон нийт, төр засгийн зүгээс түгээмэл тархацтай ашигт малтмалд харьцангуй уян хатан хандаж, компаниудад нээлттэй, тэгш боломж олгосон гэж хэлж болно. Харамсалтай нь, сүүлийн жилүүдэд олборлолт нэмэгдэх хэрээр зөрчил, гомдол гарах нь ч олширсон. Тухайлбал, хайгуулын 296 тусгай зөвшөөрөл хүчинтэй байгаа боловч эдгээрт ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа зөрчил түгээмэл. Ашигт малтмал, газрын тосны газарт ашиглалтын 14 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй. Хамгийн их тусгай зөвшөөрлийг Улаанбаатар болон Сэлэнгэ аймагт олгосон байна.

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглосон. Гэвч хууль зөрчих тохиолдол энэ салбарт цөөнгүй гарсаар. Олборлолт хийж буй зарим компани байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй байх нь нийтлэг.

Үүнд тусгай зөвшөөрөл бүхий ашиглалтын талбай нь Улаанбаатар хотын ундны усны хамгаалалтын бүстэй давхардсан зөрчил давамгайлж байна. Нийслэлийн Байгаль орчны газар болон нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар өнгөрсөн онд 96 тусгай зөвшөөрөл цуцалсан. Мөн тусгай зөвшөөрөл олгосноос хойш гурван жилийн хугацаанд ашиглаж эхлээгүй 30 гаруй аж ахуйн нэгж байгаа нь тогтоогджээ.

Газрын хэвлий ашиглах эрхтэй компанийн тоог зохистой түвшинд байлгаж, улмаар нийгмийн хариуцлага үүрүүлэхэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны бодлого чиглэж байна. Ялангуяа, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийлгэх, буух эзэнтэй, буцах хаягтай болгох шаардлагатайг Д.Сумъяабазар сайд хэлдэг. Нийслэлд гэхэд, хайрга, дайрга, элс тоосгоны шаврын нийлүүлэлтэд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 130 гаруй тусгай зөвшөөрөлтэй компани ажиллаж байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын салбарт дан дотоодын компаниуд хүч сорьдог. Гаднын тоглогч болон томоохон хөрөнгө оруулалт энэ салбарт огт нэвтрээгүй юм.

Тэрчлэн бусад түүхий эдтэй харьцуулахад, маш бага мөнгө эргэлддэг учраас хөрөнгө оруулагчдын хараанд өртөж чаддаггүй сул талтай. Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрт өнгөрсөн онд 2.4 тэрбум төгрөг орон нутгийн төсөвт төвлөрчээ. Энэ нь 2016 онтой харьцуулахад 300 орчим сая төгрөгөөр өссөн үзүүлэлт. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд ирүүлсэн тайлангаас харахад, шинээр бүртгэгдэж буй түгээмэл тархацтай ашигт малтмалын тоо маш бага хувийг эзэлжээ. Барилгын материалын түүхий эд болгон ашиглаж буй элс, хайргыг эрэх, хайх, олборлоход зардал бага гардаг.

Нарийвчилсан хайгуул хийх шаардлага ч энэ салбарт байхгүй. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт, түгээмэл тархацтай ашигт малтмалын талаар нарийн тодорхой зорилт ч алга. Харин сүүлийн жилүүдэд ипотек хэрэгжиж, барилгын салбарт орон сууцны том төслүүд хэрэгжиж эхэлсэн нь түгээмэл тархацтай ашигт малтмалын эрэлтэд нөлөөлжээ. Барилга, хот байгуулалтын яамны мэдээллээр, Улаанбаатар хотод 80 орчим мянган айлын орон сууцны барилга угсралтын ажил үргэлжилж буй. Барилгын салбарын үндсэн түүхий эд болдог түгээмэл тархацтай ашигт малтмалын салбарт орон нутгийн өмчит компани байгуулах, улмаар энэ төрлийн ашигт малтмал олборлох хандлага сүүлийн жилүүдэд нэмэгдэж, энэ хэрээр эдийн засагт үзүүлэх нөлөө сайжирчээ. Тухайлбал, Хөвсгөл аймаг чулууны үйлдвэр байгуулахаар холбогдох тендерийг зарласан бол Говь-Алтай тоосгоны үйлдвэр ойрын хугацаанд байгуулахаар төлөвлөж байна. [ЗГМ]

- **Хайгуулын 296 тусгай зөвшөөрөл хүчинтэй байгаа боловч эдгээрт ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа зөрчил түгээмэл.**
- **Хамгийн их тусгай зөвшөөрлийг Улаанбаатар болон Сэлэнгэ аймагт олгосон байна.**
- **Орон нутгийн өмчит компани байгуулах, улмаар ашигт малтмал олборлох хандлага сүүлийн жилүүдэд нэмэгдсэн.**

ХӨРШ

Нүүрсний ханш тогтворжих төлөвтэй

Н.Содонтуяа
Шинжээч

БНХАУ-ын нүүрсний ханш богино хугацаанд тогтворжих төлөвтэйг тус улсын Худалдааны яам мэдэгдлээ. Нүүрсний эрэлт буурдаг дулааны улирал эхэлж байгаатай холбоотойгоор нүүрсний зах зээлийн идэвхжил сулрах төлөвтэй байгаа аж. Тус улсад дөрөвдүгээр сарын 23-29-ний хооронд нүүрсний ханш 0.1 хувиар буурсан байна. Энэ нь өмнөх долоо хоногийн үзүүлэлтээс 0.6 хувиар буурсан дүн юм. Тодруулбал, дулааны нүүрсний ханш 0.2 хувиар, антрацит нүүрс 0.4 хувиар унасан аж. Харин коксжих нүүрсний ханш 0.5 хувиар өсчээ. БНХАУ-ын гол цахилгаан станцууд дөрөвдүгээр сарын эхний хагаст нийт 66.8 сая тонн нүүрс ашигласан байна. Энэ нь өмнөх сараас 6.7 хувиар буурсан дүн юм. Нүүрсний хэрэглээ буурч байгаа нь БНХАУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж буй чанаргүй нүүрсний гарцыг танах бодлоготой холбоотой аж. Тус улсын эрх баригчид 360 тэрбум ам.долларыг байгальд ээлтэй эрчим хүчний төслүүдэд зарцуулахаар төлөвлөсөн. Ингэснээр 2020 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний салбарт 13 сая шинэ ажлын байр бий болгохоор зорьж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Төсвийн орлого 2018 онд ДНБ-ий 27 хувьд хүрнэ

Б.Бямбасүрэн
Шинжээч

ОУВС-гийн тооцоолсноор 2018 онд Монгол Улсын төсвийн орлого дотоодын нийт бүтээгдэхүүний 27 хувьд хүрэх төлөвтэй байна. Энэ нь 2017 оны төсөөллөөс 2.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Төсвийн орлогыг бууруулж төсөөлсөн шалтгаан нь уул уурхайн бүтээгдэхүүний экспорт төдийлэн өсөхгүй байх эрсдэлтэй холбон тайлбарласан байна.

Энэ оны гуравдугаар сарын гүйцэтгэлээр улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого 50 тэрбум төгрөгөөр давж биелээд байна. Харин улсын төсвийн зардал 188 тэрбум төгрөгөөр бага



гарчээ. Үндэсний статистикийн хорооны мэдээлж байгаагаар, төсвийн орлого давж биелэхэд татварын орлого нэмэгдсэн нь голчлон нөлөөлжээ. "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн IV шатны үнэлгээний ажлын хэсэгтэй Засгийн газар уулзалтаа үргэлжлүүлж байна.

Уулзалтын дараа талууд хамтран албан ёсоор хэвлэлийн мэдээлэл хийнэ гэж Сангийн яам мэдээллээ. "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" хэрэгжиж эхэлснээс хойш 152.8 сая ам.долларын санхүүжилтийг гурван шатлалтай авсан.

Харин донор улс, байгууллагуудыг нэмсэн нийт санхүүжилтийн дүн 2017 оны эцэст 728 сая ам.долларт хүрчээ. Монголбанкны мэдээлснээр 2018 оны хөтөлбөрийн хүрээнд орж ирэх нийт санхүүжилтийн хэмжээ 836 сая ам.доллар болж өсөх юм байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

